




ХАСБАНК

ЖИЛИЙН ТАЙЛАН 2022

Энэ бол зөвхөн эхлэл



Хасчууд бид

Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, харилцагчдадаа өөрсдийн болон гэр бүлийнхээ гэрэлт ирээдүй, санхүүгийн эрх чөлөөнд хүрэх замыг бий болгоход нь туслах болно.

Бидний тэмүүлэл

Нийгмийн хариуцлагатай санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч банкйг бий болгож, Монголдоо хамгийн үнэ цэнтэй банк болно.

I 2022 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН АГУУЛГА

2022 оны онцлох

ТУЗ-ийн даргын мэндчилгээ

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Тогтвортой өсөлтийн жил

Санхүүгийн гүйцэтгэл
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
Төлөөлөн удирдах зөвлөл
Гүйцэтгэх удирдлага
Олон улсын үнэлгээ
Санхүүжүүлэгч, түнш байгууллагууд

Энэ бол ЗӨВХӨН ЭХЛЭЛ

Иргэдийн Банк
Бизнес Банк
Лизинг
Цахим шилжилт
Эко Банк
Мэдээллийн технологи
Нийгмийн хариуцлага

Санхүүгийн үзүүлэлт

Бизнесийн орчин
Макро эдийн засгийн төлөв
Банкны салбар
Санхүүгийн үр дүн, удирдлага
Эрсдэлийн удирдлага
Хүний нөөц
Банкны засаглал

Аудитлагдсан санхүүгийн тайлан

Хараат бус аудиторын тайлан
Аудитлагдсан санхүүгийн тайлан

2022 оны онцлох

Нийт хөрөнгө
3.9 их наяд




Зээлийн багц
2.0 их наяд

Хадгаламж
2.4 их наяд

Салбар
71

Ажилтан
1,323


Харилцагч
~1 сая




Цэвэр ашиг

+123.4%


Тэрбум төг.



Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (%)



Өөрийн хөрөнгийн өгөөж (%)



ТУЗ-ийн даргын мэндчилгээ



“2022 он сорилт бэрхшээлээр дүүрэн байсан ч банк 105.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны 75.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай харьцуулахад 41%-аар өссөн үзүүлэлт юм.

Энэ нь бидний 2019 оны эхнээс эхлүүлсэн шинэ стратегиа сахилга баттайгаар хэрэгжүүлсний үр дүн бөгөөд сүүлийн жилүүдэд банк жил дараалан амжилттай ажиллаж, маш сайн үр дүнд хүрч чадлаа.”

Ковид 19-ийн хямрал, хилийн хоригийн улмаас үүссэн гадаад валютын хомсдол, нийлүүлэлтийн тасалдлаас үүдэлтэй өндөр инфляц, Орос-Украины мөргөлдөөн, үүнтэй холбоотойгоор авагдсан хориг арга хэмжээнүүд, өсөлт саармагжсан макро эдийн засгийн хямрал, банкнуудын дүрмийн санг нэмэгдүүлэх талаар зохицуулагч байгууллагаас баримталж буй бодлого, түүнчлэн хөрөнгийн чанарын үнэлгээ, Банкны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу олон нийтэд хувьцаа гаргаж банкнийг хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, мөн Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангах зорилгоор Тэнгэр Санхүүгийн Нэгдэлийг бүхэлд нь өөрчлөн байгуулах гээд олон нугачаа бүхий цаг хугацааны дундуур бид энэхүү амжилтад хүрч чадсан юм.

Дөрвөн жилийн тэртээ бидэнтэй нүүр тулсан бугшсан асуудлын цар хүрээ, мөн энэ хугацаанд туулсан амаргүй, төвөгтэй олон тооны гадаад хямрал зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзвэл сүүлийн дөрвөн жилийн ололт амжилтын далайц онцгой юм.

Сүүлийн арван жилд ХасБанк анх удаа 2020 оны ашгаасаа 7.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараасан бол 2021 онд бид үүнийг хоёр дахин нэмэгдүүлж 15.0 тэрбум төгрөг болгон өсгөсөн. Түүнчлэн 2022 онд ногдол ашгаа ахин хоёр дахин нэмэгдүүлэх санал дэвшүүлж, 30 тэрбум төгрөгт хүргэлээ. Энэ утгаар нь авч үзвэл, банк түүхэн 20 жилийн хугацаандаа хуваарилсан нийт ногдол ашиг ердөө 3.3 тэрбум төгрөг байсан юм.

2022 он бусад талаараа ч олон дээд амжилт тогтоосон жил байлаа. Манай банкны 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлт 20%-аас дээш байгаа нь салбартаа шилдэг үзүүлэлтүүдийн нэг бөгөөд Монголбанкнаас тогтоосон 12.5%-аас хамаагүй дээгүүр байгаа юм. Мөн 2022 онд өөрийн хөрөнгийн өгөөж 24.7% болсон нь маш бахархмаар үзүүлэлт юм. Түүнчлэн, бид хөрвөх чадвараа тогтмол өндөр түвшинд барьж чаджээ. Манай хөрвөх чадварын харьцаа 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар 41%-тай байв.

Сүүлийн хэдэн жилийн хугацаан дахь макро эдийн засгийн чанга нөхцөл байдал дунд Банк чанаргүй зээлийн болон өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө (ӨБҮХХ)-ийн хэмжээг бууруулж чадлаа. Үүний зэрэгцээ бид сан байгуулахдаа хашир хандаж чанаргүй зээлийн санг 132%-аар, ӨБҮХХ-ийн нөөцийн санг 92%-аар байгуулж ажиллалаа. Сангийн нийлмэл харьцаа (чанаргүй зээлийн болон ӨБҮХХ-ийн) 2018 оны эцсийн байдлаар дөнгөж 50% байсантай харьцуулахад 2022 оны эцэс гэхэд 116% хүртэл өссөн байна.

Мөн, бид сүүлийн дөрвөн жилийн хугацаанд зардлаа маш хатуу хянаснаар орлого зарлагын харьцааг аажмаар бууруулж чадсан. 2018 онд 80% байсан орлого зарлагын харьцааг бид 2022 онд 39.9% болгон бууруулжээ.

Технологи бол бидний урт хугацааны амжилтын чухал элемент. Бид 2022 онд банкны үндсэн системийн шилжилтийг амжилттай хийж чадлаа. Энэ завшааныг ашиглан шилжилтийг амжилттай гүйцэтгэж чадсан мэдээллийн технологийн болон төслийн багийнханд, түүнчлэн банкныхаа бусад ажилтнуудад талархал илэрхийлье. 2021 онд бид мобайл банкны шинэ аппликейшнийг нэвтрүүлсэн. Бидний аппликейшнийг харилцагчид маань нааштайгаар хүлээн авсан бөгөөд бидний зүгээс уг аппликейшнийг илүү олон үйлдэлтэй болгохоор ажиллаж байна.

Сүүлийн гурван жилийн хугацаанд Ковид-19-өөс шалтгаалсан гүйцэтгэлийн саад тотгорыг үл харгалзан мэдээллийн технологийн салбарт томоохон ахиц дэвшил хийсэн ч бид цаашид илүү их зүйлийг хийх шаардлагатай байна.

Бид 2023 онд олон нийтэд хувьцаагаа санал болгоно. Энэ нь Монгол Улсын иргэд Банкны хувьцааг шууд худалдан авч, ХасБанкны бахархмаар түүхийн нэг хэсэг болох боломжийг олгоно гэж найдаж байна. Цаашид хувьцаа нийтэд санал болгох талаар бид журмын дагуу, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржтэй зөвшилцсөний үндсэн дээр цаг тухайд нь мэдээлэх болно.

Гаднын олон таагүй хүчин зүйлс, бусад бэрхшээлийг даван туулж энэхүү өндөр амжилтад хүрч нүүр бардам гүйцэтгэлийг үзүүлсэн ажилтнуудаараа би маш их бахархаж байна. Ташрамд хэлэхэд, биднийг бүхий л талаар дэмжин, удирдан чиглүүлж байсан Төлөөлөн удирдах зөвлөл болон хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлье.

Бид мөн Банкныхаа тулгуур баганыг бэхжүүлж, ойрын ирээдүйд мэдэгдэхүйц өсөлтийг бий болгох үндэс суурийг тавьж чадлаа. Өнгөрсөн дөрвөн жилд бид маш сайн ажилласан, одоо ч бидний ирээдүй өнгөрсөн жилүүдээс илүү гэрэл гэгээтэй байх болно гэдэгт эргэлзэхгүй байна.

Санжай Гупта
ТУЗ-ийн дарга

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, хамтрагч нараа,

Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд хамгийн их сорилттой нүүр тулсан 2022 онд биднийг чин сэтгэлээсээ сэтгэл харамгүй дэмжсэн ТУЗ-ийн дарга ноён Санжай Гупта, ТУЗ-ийн гишүүд, түүнчлэн хараат бус гишүүд, хувьцаа эзэмшигчдэдээ энэхүү захидлаараа дахин талархал илэрхийлье.

Мөн Удирдлагын багтаа болон ХасБанкны 1,300 гаруй ажилтнууддаа онцгойлон талархъя. Тэд туйлын таатай бус нөхцөл байдалд бүхий л хүч чармайлтаа гаргаж харилцагчид, хувьцаа эзэмшигчид болон хамтрагчдадаа үйлчилгээ үзүүлсэн.

2022 оны жилийн тайландаа Ковид-19-н дараах үед бидэнд урьд өмнө тулгарч байгаагүй сорилтууд, геополитикийн нөлөөлөл, Банкны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу банкнийг нээлттэй хувьцаат компани болгох бэлтгэл ажлуудын талаар өгүүлэх болно. Түүнчлэн стратегийн санаачилгууд, харилцагчдыг дэмжих, ажилтнууддаа чиглэсэн арга хэмжээнүүдийн талаар санал бодлоо хуваалцахаас гадна нээлттэй хувьцаат компани болох дараагийн аялалд бэлдэж буй энэ үед 2023 оны хэтийн төлөвийг ч мөн танилцуулах болно.

► Ковид-19-ийн дараах сэргэлт: макро эдийн засаг, геополитикийн шинэ сорилтууд үргэлжилсээр байна

Бид Ковид-19 дэлхийн хямралыг даван туулсан ч урьд өмнө хэзээ ч байгаагүй шинэ сорилтоор 2022 оныг эхлүүлсэн. Монгол Улс макро эдийн засгийн сорилтуудтай тулгарсан нь Ковид-19 тахалтай байсан ихэнх улс орнуудтай ижил төстэй юм. Инфляц хоёр оронтой тоогоор өсөж, уул уурхайн экспортын нийт хэмжээ болон гадаад валютын нөөц багасаж, төгрөгийн ханш суларснаар Төв банкны бодлогын хүү нэмэгдсэн нь ХасБанкны хувьд зарим стратегия эргэн харах шаардлагатай тулгарсан.

Геополитикийн гэнэтийн өөрчлөлтүүд, Орос Украины мөргөлдөөн нь Монгол улсын эдийн засаг, банкны салбарт шинэ сорилтуудыг бий болгосон. Манай улсын геополитикийн өвөрмөц байршил буюу Монгол Улс Орос, Хятад улсын дунд оршдог учраас гол гол бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээ тасалдсан. Дэлхийн хориг арга хэмжээнүүд нь хил дамнасан төлбөр тооцоог дуусгах, өндөр инфляцад дарамт үзүүлэх нэмэлт төвөгтэй байдлыг бий болгосон. Инфляцыг хяналттай байлгахын тулд Төв банкнаас 2022 оныг дуустал мөнгөний бодлогоо чангатгаж бодлогын хүүг 6%-аас 13% болгож нэмэгдүүлсэн нь банкнаас актив пассивын удирдлагыг долоо хоног тутам сайтар хянах шаардлагатай болсон.

► Банкны шинэчлэл: гэнэтийн сюрприз ба дараагийн алхмууд

2022 он санхүүгийн салбарын түүхэн чухал жил буюу банкнуудын шинэчлэлийн жил байлаа. Банкны тухай хуульд 2021 оны 1-р сард орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд системийн бүх банкууд 2022 оны 6-р сарын 30-ны өдрийн дотор IPO хийх шаардлагатай болсон. Манай багийн хувьд андеррайтерууд, хөндлөнгийн үнэлгээний компани, хөндлөнгийн хуулийн фирм, аудиторуудын хамт IPO хийх бэлтгэлээ базаасан. Харамсалтай нь УИХ-аас Банкны тухай хуулийн нээлттэй компани болох заалтыг хэрэгжүүлэх хугацааг 2023 оны 6-р сарын 30 хүртэл сунгасан. Түүнчлэн системийн банкууд сүүлийн таван жилд хоёр дахь удаагаа Активын чанарын үнэлгээ (AQR) хийлгэх шаардлагатай болсон. Эрсдэлийн удирдлага, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээ, өөрийн туршлагадаа тулгуурлан ХасБанк маш сайн бэлтгэсэн бөгөөд үнэлгээний үр дүн нь манай банкны эрсдэлийн

зохистой удирдлага, эрсдэлийн нөөц бүрдүүлж буй консерватив туршлагыг дахин баталгаажуулсан.

Банкны тухай шинэ хуультай холбоотойгоор бид ХасБанкийг өөрийн хүчтэй хөрөнгөтэй, эрүүл ашигтай, хангалттай зээлийн нөөцийн сантай, дижитал технологид оруулсан хөрөнгө оруулалттай, хувьцаа эзэмшигчдэдээ өгөөжтэй, тогтвортой ногдол ашигтайгаар дахин байршуулах зорилтоо хэрэгжүүлсээр байна. Бид IPO хийх хуулийн шинэ сунгасан хугацааг баримтлан ажиллаж байна.

Хувьцаа эзэмших дээд хязгаарыг 20%-аар тогтоосон банкны шинэ хууль гарахтай холбогдуулан бид ТэнГэр Санхүүгийн Нэгдэл (ТСН)-ийн хувьцаа эзэмшигчдийг IPO гаргасны дараа шууд ХасБанкны хувьцаа эзэмшигч болгох зорилготойгоор ТСН-д бүтцийн өөрчлөлтийг хийж дуусгалаа.

► 2019-2022 оны стратегийн тойм: Тогтвортой гүйцэтгэлийг хангах нь

2019 онд хүрсэн амжилт бидний стратеги зөв зүйтэй болохыг дахин харуулсан бөгөөд 2020, 2021 онд өсөлтийг үргэлжлүүлэх эрч хүчийг бидэнд мэдрүүлсэн. Стратегийн өөрчлөлтийн үр нөлөө 2022 онд илүү тодорч бид өмнө нь хүрч байгаагүй санхүүгийн гайхалтай үр дүнд хүрлээ.

2019 онд хэрэгжүүлсэн стратегийг дахин онцлон тэмдэглэх нь зүйтэй. Бид дараах тулгуур асуудалд анхаарлаа хандуулсан болно.

1. ХасБанкны үндэс суурийг бататгахын зэрэгцээ ирээдүйн өсөлтийг хангах байр сууриа тодорхойлох нь бидний гол стратеги байв. Санхүүгийн хатуу чанд сахилга баттай, эрсдэлээ хянаж ашигтай ажиллах нь бидний өсөлтийн зорилго байв.
2. Бид банкны хөрөнгийн шинэ удирдамжийг хангахын тулд нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг хуримтлагдсан ашгаараа органик байдлаар бий болгохыг зорьсон. Хувьцаа эзэмшигчдээс нэмэлт хөрөнгө босгохгүйгээр нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн шинэ доод шаардлагыг дагаж мөрдөх.
3. Зээлийн чанарт анхаарч, хангалттай нөөц бүрдүүлэх. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд бид үйл ажиллагаанаас илүү дорвитой ашиг олох шаардлагатай болсон.
4. Хувьцаа эзэмшигчдэд хүртээх үнэ цэнийг сайжруулж, өөрийн хөрөнгийн өгөөжийг 20%-аас дээш хэмжээнд байлгах. Өөрийн хөрөнгийн өгөөж хамгийн багадаа 20%-тай байлгахын тулд бид нэгд, пассивын зохистой удирдлагад анхаарч цэвэр хүүгийн орлогын маржин өсгөх, хоёрт, банкны үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлж зардал орлогын харьцаа (83.9%)-г 50-иас доош хувь болгон сайжруулахын тулд санхүүгийн хатуу сахилга баримтлах бодлого баримталсан.

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

5. Цахим өөрчлөлтийг хурдасгаж, мэдээллийн технологийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх. Олон жилээр сунжирсан мэдээллийн технологийн асуудлуудыг шийдвэрлэх том даалгавар бидэнд байсан. Мэдээллийн технологийн зардал нэмэгдэж, иргэдийн зээл өрсөлдөх чадваргүй болсоор байв. Мэдээллийн технологийн давуу талыг ашиглах нь иргэдийн зээлийг нэмэгдүүлэх гол тулгуур юм. Цахим өөрчлөлтийг хурдасгах нь банканд богино хугацаанд чухал үүрэгтэй төдийгүй мөн урт хугацааны ирээдүйд зайлшгүй хэрэгтэй. Энэ зорилтыг биелүүлэхийн тулд бид цахимжуулах, автоматжуулах санаачилгад анхаарлаа хандуулсан. Бидний эхлүүлсэн цахим өөрчлөлтийн гол төслүүдэд банкны үндсэн системийн өөрчлөлт, мобайл банкны шинэ платформ нэвтрүүлэх, зээл олгох, зээл ангилах төрөл бүрийн үнэлгээний хэрэгслийг бий болгох, чухал процессуудыг автоматжуулах зэрэг багтсан.

Бүтээмжийг сайжруулах нь. 2022 онд бид санхүүгийн болон үйл ажиллагааны хувьд дахин өндөр амжилт гаргасныг дуулгахад таатай байна. ХасБанк 105.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, өөрийн хөрөнгийн өгөөж 24.7%-д хүрсэн нь зорилтот сегментүүдийн тогтвортой өсөлт, эрсдэлийн ухаалаг удирдлага, зардлын сайн удирдлага болон хөрөнгийг үр ашигтай зарцуулалттай холбоотой.

Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 20.1%-д хүрсэн нь зохицуулах байгууллагын тавьж буй хөрөнгийн шаардлагаас 760 суурь нэгжээр илүү байгаа нь биднийг цаашдын өсөлт гаргахад хүчтэй болгож байна. Эрсдэлийн удирдлага, зээлийн андеррайтерийн бодлого журмыг сайжруулахад үлэмж их нөөцийг зарцуулж, чанаргүй зээл болон өмчлөх бус үндсэн хөрөнгийг идэвхтэй удирдсанаар чанаргүй зээлийг 4.0%-д барьж чадсан. Мөн чанаргүй зээл болон өмчлөх бус үндсэн хөрөнгийн нөөцийн сангийн хүрэлцээ 116 %-тай байна.

Хадгаламж, гадаад эх үүсвэрийг оролцуулан өр төлбөрийн бүтцийг улам оновчтой болгож актив пассивыг удирдах арга барилаа сайжруулсаар байна. Үүний үр дүнд хүүгийн цэвэр маржин 7.8% болсон. Бид зардлын сахилгыг хариуцлагатайгаар чанд мөрдөж, зардлын бүтцийг хувьсах хэлбэрт шилжүүлснээр зардал орлогын харьцаа сайжирч 39.9% хувь болсон. Нээлттэй компани болох хөгжлийн дараагийн үе шат руу шилжих гэж буй энэ үед бидний санхүүгийн болон үйл ажиллагааны загвар нь ирээдүйн өсөлтийн тулгуур хэвээр байх болно гэдэгт манай удирдлагын баг итгэж байна.

Гайхалтай үр дүнд, сайн гүйцэтгэлд зөвхөн багийн маш сайн хүчин чармайлтаар л хүрдэг. Олон жилийн турш биднийг дэмжиж, итгэл хүлээлгэсэн Хувьцаа эзэмшигчдэдээ баярлалаа. Мөн Төлөөлөн Удирдах зөвлөл манай банкны урьд өмнө байгаагүй эргэлт хийхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. ТУЗ-ийн бүх гишүүдээ баярлалаа гэж хэлмээр байна. Эцэст нь хэлэхэд, 1,300 гаруй хүчирхэг, нэгдмэл амь нэгтэй Хасчууддаа өдөр шөнөгүй хичээнгүй ажилласан та бүхэндээ баярлалаа гэж хэлмээр байна.

Дижитал шилжилт. Харилцагчид энгийн бүтээгдэхүүн худалдан авахдаа дижитал сувгийг сонгох болсон нь улам тодорхой болж байна.

Харилцагчдын хувьд гар утсыг юуны түрүүнд сонгох болсноор компаниудын хувьд хурдан бөгөөд харилцагч, үйлчлүүлэгчдэдээ ээлтэй үйлчилгээг санал болгох шахалтыг бий болгосон.

Дижитал шилжилтийн үндэс нь найдвартай, баталгаатай банкны үндсэн систем юм. Хэдэн жилийн өмнө бид дижитал өөрчлөлтийн нэг хэсэг болгон банкны үндсэн системээ (БҮС) Oracle-aac Infosys руу шилжүүлэх стратегийн шийдвэр гаргасан.

Аливаа иж бүрэн дижитал банкны үндсэн өөрчлөлтийн төсөл нарийн нягт төлөвлөлтийг шаарддаг. Дотоодын болон гадаадын багуудын уялдаа холбоо маш чухал. Үүнээс гадна БҮС-тэй 20 гаруй нэн чухал системийг нэгтгэж холбох нь маш том ажил байсан. Төсөл хэрэгжүүлсэн 18 сарын хугацааны дараа төслийн баг банкны БҮС-ийг Infosys-ээс Finacle руу хамгийн бага сул зогсолттой шилжүүлж чадсанд би бахархаж байна. Шинэ БҮС нь технологийн хурдан өөрчлөлтөд дасан зохицох чадвартай, тогтвортой, уян хатан арын системээр хангах болно. Бидний ирээдүйн дижитал банкны хүсэл эрмэлзлийг манай шинэ үндсэн систем нэвтрүүлэх боломжийг бүрдүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Иргэдийн банкны харилцагчдаа зориулан 2021 онд ашиглалтад оруулсан Дижитал банкны платформыг үргэлжлүүлэн сайжруулж байна. Одоо манай харилцагчид энэхүү платформыг ашиглан банкны салбарт биечлэн ирэхгүйгээр зээл, хадгаламж зэрэг санхүүгийн ихэнх үйлчилгээг авах боломжтой боллоо. Төлбөрийн гүйлгээний 97 гаруй хувь нь дижитал суваг ашиглан хийгдэж байна. Дижитал банкны платформд шинэ боломжуудыг үргэлжлүүлэн нэвтрүүлснээр бид дижитал банкны хэрэглэгчид, дижитал гүйлгээний тоо ирэх жилүүдэд улам нэмэгдэнэ гэж найдаж байна. 2022 онд бид аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд зориулсан Дижитал банкны платформыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ нь илүү боломжуудыг бий болгоно.

Төрөл бүрийн платформуудтай тасралтгүй түншлэх нь чухал ач холбогдолтой бөгөөд API-ээр дамжуулан гуравдагч талын үйлчилгээ үзүүлэгчидтэй системээ үргэлжлүүлэн холбох болно. Бид мобайл банкны аппликейшнээ тасралтгүй сайжруулж, зээлийн процессыг үлэмж сайжруулах зорилгоор зээлийн оноо, баримт бичгийн удирдлага, дүн шинжилгээ хийх платформ хүртэл зээл олгох үйл явцыг эрс шинэчилж байх болно. Дижиталчлалын эрин зуунд харилцагчдад итгэх итгэл, найдвартай байдлыг баталгаатай болгохын тулд дата өгөгдөл, кибер аюулгүй байдалд тасралтгүй хөрөнгө оруулах болно.

Технологийн хурдацтай өөрчлөгдөж буй ертөнцөд дижитал шилжилт нь байнга үргэлжлэх санаачилга гэдгийг бид бүрэн ойлгож байна. ХасБанк ирэх жилүүдэд ч илүү дижитал болгох зорилттой байх болно.

Эко / Ногоон санхүүжилт. ХасБанк нь Ногоон санхүүжилтийн анхдагчдын нэг бөгөөд бид НҮБ-ын Уур Амьсгалын Ногоон Сан (УАНС)-гийн итгэмжлэлийг авсан дэлхийн анхны хувийн хэвшлийн байгууллага юм. 2016 онд УАНС магадлан итгэмжлэгдсэнээс хойш ХасБанк 87.4 сая ам.долларын 9 төсөл хэрэгжүүлээд байна.

УАНС нь байгууллагуудыг 6 жилийн дараа дахин магадлан итгэмжлэхийг шаарддаг. 2022 онд ХасБанк УАНС-гийн зөвлөлөөс дахин магадлан итгэмжлэлийг хүлээн авлаа. ХасБанкны нэрийн өмнөөс УАНС-гийн хамт олон болон УАНС-гийн Удирдах зөвлөлд ХасБанканд итгэж байгаад гүнээ талархаж байгаагаа илэрхийлэе. Уур амьсгалын Ногоон сан (УАНС)-гийн итгэмжлэгдсэн банкны хувьд хувь хүн, бизнес эрхлэгчдэд зориулсан зээлийн хөтөлбөрөөр дамжуулан уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах санаачлагыг дэмжих амлалтаа үргэлжлүүлнэ. УАНС-аар дахин магадлан итгэмжлэгдсэнээр манай банк Парисын хэлэлцээрт нийцүүлэн ХасБанк Ногоон санхүүжилтийн санаачлагыг үргэлжлүүлэх боломжийг олгоно.

Төлөв

Банкийг урт хугацааны, тогтвортой бизнес гэж үзэн төлөвшүүлж, хөгжүүлж ирснээрээ бид сүүлийн 21 жилийн хугацаанд зах зээлд нэр хүндтэй болж чадсан.

Манай нэр хүндтэй хувьцаа эзэмшигчид ХасБанканд зөвхөн хөрөнгө оруулаад зогсохгүй компанийн сайн засаглал, техникийн туршлагаар дамжуулан “ноу-хау” шилжүүлэх, олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлэх замаар оюуны өмчид хөрөнгө оруулалт хийдэг.

2023 оны 6-р сараас өмнө хөрөнгийн бирж дээр олон нийтэд хувьцаа санал болгож нээлттэй хувьцаат компани болох, 2023 оны эцэс гэхэд хувьцаа эзэмших 20%-ийн дээд хязгаарыг дагаж мөрдсөнөөр бид барианы шугам руу ойртож байна. Нээлттэй хувьцаат компанийн хувьд бид банкныхаа өсөлтийг удирдаж, хөрөнгийн зах зээл, хөрөнгө оруулагчдынхаа хүлээлтийг удирдах шаардлагатай.

Бид байгууллагын хувьд ашигтай ажиллах, эрсдэлийг хянаснаар өсөлтийг бий болгоход суралцсан. Бидний стратеги, бизнесийн загвар маш сайн үр дүнд хүрсэн ч одоо бид бүтээгдэхүүн, үйлчилгээ, хүргэх сувгуудаа улам сайжруулах ёстой.

Бид багаараа тааламжтай бус нөхцөл, бэрхшээлийг шантралгүй даван туулах, гэнэтийн зүйлд бэлэн байж сурсандаа би бахархаж байна. Нээлттэй хувьцаат компанийн хувьд бид харилцагч, түншүүддээ үнэ цэнийг хүргэх, ажилтнууддаа анхаарал халамж тавих, хувьцааны өндөр гүйцэтгэл, тогтвортой хувьцааны ногдол ашгаар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг нэмэгдүүлэхийн тулд бүхий л хүчин чармайлтаа зориулах болно.

Гүмэнжавын Цэвэгжав
Гүйцэтгэх захирал



Санхүүгийн гүйцэтгэл


Зээлийн багц

Тэрбум төгрөг




Чанаргүй зээл

%



Нийт эх үүсвэр


Тэрбум төгрөг



Харилцах, хадгаламж, гадаад эх үүсвэрийн нийлбэр.


Цэвэр ашиг

Тэрбум төгрөг



Өөрийн хөрөнгийн өгөөж


%



Тухайн оны цэвэр ашгийг оны эхний өөрийн хөрөнгөд харьцуулан тооцсон.


Ногдол ашиг

Тэрбум төгрөг



Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

ХасБанк нь Тэнгэр Санхүүгийн Нэгдэл (ТСН) ХХК-ийн бүрэн эзэмшлийн охин компани юм. ТСН ХХК нь олон улсын санхүүгийн байгууллагууд, дотоод болон гадаадын нэр хүндтэй компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд, төрийн бус байгууллагууд болон хувь хүмүүсээс бүрдсэн хувьцаа эзэмшигчидтэй ба одоогоор Монгол улсын банк, санхүүгийн салбарт ийм олон талын хувьцаа эзэмшигчдийн бүтэцтэй цорын ганц компани юм.



Төлөөлөн удирдах зөвлөл

ТУЗ-ийн дарга

Санжай Гүпта
ТУЗ-ийн дарга

ТУЗ-ийн гишүүд

Гүмэнжавын Цэвэгжав
ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал

Альбертус Браггинк
ТУЗ-ийн гишүүн

Нямтайширийн Цэлмүүн
ТУЗ-ийн гишүүн

Сюзанна Карр
ТУЗ-ийн гишүүн

Майкл Мадден
ТУЗ-ийн гишүүн

Баянсаны Уламбаяр
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ив Жако
ТУЗ-ийн гишүүн

Эрик Версавел
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Андржеж Витак
ТУЗ-ийн гишүүн

Нираз Вэдва
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Гүйцэтгэх удирдлага



Гүмэнжавын Цэвэгжав

Гүйцэтгэх захирал
ХасБанканд: 2011 оноос
Ажлын туршлага: 19 жил



Ганзоригийн Эрдэнэбаяр

Санхүү хариуцсан захирал
ХасБанканд: 2005 оноос
Ажлын туршлага: 18 жил



Энэбишийн Уламбаяр

Иргэдийн банк
хариуцсан захирал
ХасБанканд: 2013 оноос
Ажлын туршлага: 23 жил



Бавааны Еркин

Байгууллагын банк
хариуцсан захирал
ХасБанканд: 2002 оноос
Ажлын туршлага: 20 жил



Серикжаны Дауренбек

Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд
лизинг хариуцсан захирал
ХасБанканд: 2000 оноос
Ажлын туршлага: 25 жил



Илия Аврамов

Эрсдэл хариуцсан захирал
ХасБанканд: 2019 оноос
Ажлын туршлага: 25 жил



Ганзоригийн Зул

Үйл ажиллагаа хариуцсан
захирал
ХасБанканд: 1999 оноос
Ажлын туршлага: 24 жил



Хүрэлбаатарын Өнөрбат

Мэдээллийн технологи
хариуцсан захирал
ХасБанканд: 2012 оноос
Ажлын туршлага: 20 жил



Нямсүрэнгийн Мөнхцэлмэг

Хууль хариуцсан захирал,
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
ХасБанканд: 2022 оноос
Ажлын туршлага: 16 жил



Энхбаярын Ундармаа

Ерөнхий аудитор
/ТУЗ-ийн Аудитын хороонд шууд
тайлагнадаг/
ХасБанканд: 2008 оноос
Ажлын туршлага: 25 жил

Олон улсын үнэлгээ

ХасБанк нь дэлхийн хамгийн нэр хүндтэй үнэлгээний агентлагууд болох Moody's Investors Service болон Fitch Ratings байгууллагуудаар өөрийн зээлжих зэрэглэлийг 2008 оноос хойш тасралтгүй үнэлүүлж, хамтран ажиллаж ирлээ. 2022 онд тус агентлагууд ХасБанкны үнэлгээ хийж, зээлжих зэрэглэлийг хэвээр үлдээж, баталгаажууллаа. ХасБанкны зээлжих зэрэглэлийн үнэлгээ Монгол Улсын Засгийн Газрын зээлжих зэрэглэлийн үнэлгээтэй ижил түвшинд байна.

Сүүлийн үеийн явцын мэдээлэл:

- 2022 оны 11 дугаар сард Moody's: агентлагаас ХасБанкны зээлжих зэрэглэлийг B3, ирээдүйн хандлагыг тогтвортой хэвээр хадгаллаа.
- 2022 оны 7-р сард Фитч агентлаг ХасБанкны зээлжих зэрэглэлийг мөн хэвээр үлдээж, B/тогтвортой гэж үнэлэн баталгаажууллаа.

Moody's INVESTORS SERVICE

"Мүүдиз" олон улсын үнэлгээний байгууллага (www.moody.com) нь дэлхийн нийт улс орны зээлжих чадвар болон томоохон аж ахуйн нэгж, байгууллагуудад санхүүгийн зэрэглэл тогтоогч.

	2022/11
УХ/БХ гадаад валютаар татан төвлөрүүлсэн хөрөнгө	B3/NP
УХ/БХ төгрөгөөр татан төвлөрүүлсэн хөрөнгө	B3/NP
Зээлжих чадварын үнэлгээ	b3
Үнэт цаас гаргагчийн үнэлгээ	B3/NP
Хандлага	Тогтвортой



Moody's

Урт хугацаат гадаад валютаар хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл

B3/Тогтвортой

FitchRatings

Фитч Үнэлгээний Компани (www.fitchratings.com) нь Ази Номхон далайн бүс төдийгүй дэлхийн зах зээл дээр тэргүүлдэг зээлжилт болон санхүүгийн зэрэглэл тогтоогч.

	2022/07
УХ гадаад валютаар хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл	B/Тогтвортой
БХ гадаад валютаар хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл	B
УХ төгрөгөөр хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл	B/Тогтвортой

FitchRatings

Урт хугацаат гадаад валютаар хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл

B/Тогтвортой

Санхүүжүүлэгч түнш байгууллагууд

+230
сая ам.доллар

2022 онд олон улсын санхүүгийн
байгууллагуудаас татсан эх үүсвэр

Бид олон улсын санхүүгийн байгууллагуудаас
эх үүсвэр татан жижиг дунд бизнес, эмэгтэй
бизнес эрхлэгч, ногоон бизнес, төсөл
хөтөлбөрүүдийг дэмждэг.

Санхүүжүүлэгч түнш байгууллагууд



Корреспондент банкууд



Иргэдийн Банк

Иргэдийн зээл

Бид бизнесийн орлоготой иргэн, аж ахуйн нэгжид үйл ажиллагааны чиглэл, бизнесийн онцлогт тохирсон эргэлтийн хөрөнгийн зээл, хөрөнгө оруулалтын зээлийг олгохоос гадна орчин үеийн санхүүгийн хэрэгслүүд болох баталгаа, аккредитивын бүтээгдэхүүнийг санал болгон хамтран ажиллаж байна.

Зээлийн багц
1,403 тэрбум.₮

Нийт харилцагч
949,827



Чанаргүй зээл
3.8%

Картаар үйлчлэгч байгууллагуудад зориулан “Онлайн мерчантын зээл”-ийг зах зээлд шинээр нэвтрүүлснээр бичил, жижиг бизнес эрхлэгч харилцагчид маань ажлын байр, лангуугаа орхиж ашиг орлогоо алдах шаардлагагүйгээр дижитал банкаараа зээл авах боломжтой боллоо.

Цалингийн орлоготой иргэдэд цалингийн зээл, хэрэглээний худалдан авалтын зээл, кредит карт гэх мэт олон төрлийн зээлийн бүтээгдэхүүнийг санал болгон ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний “Хөдөө аж ахуйг дэмжих зээл”-ийн хүрээнд ХасБанк бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд жилийн 3%-ийн хүүтэй 19 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Мөн Монголбанк болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтарсан Алт-2 хөтөлбөрийн зээл, Шатахууны нөөц бүрдүүлэх зээлүүдэд хамтран ажиллаж өөрийн харилцагч байгууллагууддаа бага хүүтэй, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг дамжуулан олгож ажиллаа.

Засгийн Газрын 6%-ийн хүүтэй орон сууцны ипотекийн зээлийн олголтыг үргэлжлүүлж 2022 онд нийт 844 харилцагчид 64.7 тэрбум төгрөгийн зээл олгосны 46.8 тэрбум төгрөгийн зээлийг Монголбанкны эх үүсвэрээр, 17.9 тэрбум төгрөгийн зээлийг өөрийн эх үүсвэрээр тус тус санхүүжүүлсэн байна. Мөн 2022 онд МИК 29, 30, 31-р багцуудад нийт 778 зээлийн 48.2 тэрбум төгрөгийн дүнтэй зээлийн багцыг Үнэт цаасжуулан ажиллаа.



Улаанбаатар хотод 32
Орон нутагт 39

Монгол эх орныхоо дөрвөн зүг найман зовхист 1,000,000 гаруй харилцагчдаа банкны үйлчилгээг уламжлалт болон дижитал сувгаар хүргэж байна.

Харилцах, хадгаламж

Иргэдээс татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийн багц өмнөх оноос 8.5%-аар буюу 190 тэрбум төгрөгөөр өсөж 2.4 их наяд төгрөгт хүрлээ. Нийт харилцах, хадгаламж эзэмшигчийн тоо 949 мянгад хүрсэн бөгөөд үүний 250 мянган данс нь улс орны ирээдүй болсон хүүхдүүд байна.

Эх үүсвэрийн багц
2,421 тэрбум.₮

Харилцагч хүүхдүүд
250,000

2021 онтой харьцуулахад хүүхдийн хадгаламжийн багц 14.5%, харилцах, хугацаагүй хадгаламжийн багц 16.7%-аар тус тус өссөн байна.

ХасБанк нь 2002 онд Монголын банк санхүүгийн зах зээлд хүүхдийн хадгаламжийг “Ирээдүйн саятан” нэртэйгээр анхлан нэвтрүүлсэн бөгөөд 2022 онд энэхүү бүтээгдэхүүнийхээ 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүллээ. 20 жилийн ойн хүрээнд бид Ирээдүйн саятан хүүхдийн хадгаламжийн Rebranding-ийг хийж шинэ өнгө төрхтэйгөөр хүүхэд багачууддаа эргэн ирлээ.

Энэхүү rebranding-ийн хүрээнд 18 жил ХасБанканд ирээдүйн саятан хадгаламж эзэмшсэн харилцагчдын төлөөллийг хүлээн авч уулзан, сэтгэгдлийг сонсон, хүүхэд багачуудад хуримтлал үүсгэхийн давуу тал, ач холбогдлын талаар таниулах ажлуудыг хийлээ.

Мөн улсын 1-р төрөх эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Гурван гал эмнэлгүүдтэй хамтран ажиллаж шинээр мэндэлсэн 450 орчим бяцхан үрсэд тус бүр 50,000 төгрөгөөр “Ирээдүйн саятан” хадгаламж нээж өглөө.




Иргэдийн Банк

Дижитал банк

Дижитал банкны үйлчилгээнд технологийн дэвшилтэт шийдлийг тогтмол нэвтрүүлж, хэрэглэгчийн зан төлөв, хэрэглээнд суурилсан хялбар функцуудыг шинээр нэвтрүүллээ. Тухайлбал, картаа зайнаас удирдах, онлайн зээл авах гэх мэт олон боломж бүхий шинэчилсэн дижитал банкны веб болон аппликейшн хувилбарыг зах зээлд бүрэн нэвтрүүлж, өмнөх хувилбарын хэрэглэгчдийг 100% амжилттай шилжүүллээ. Тайлант хугацаанд дижитал банкны идэвхтэй харилцагчийн тоо өмнөх онтой харьцуулахад 26%-аар нэмэгдэж, гүйлгээний тоо 86%-аар өссөн байна. Үүний үр дүнд 2022 онд банкны хэмжээнд хийгдсэн нийт гүйлгээний 97% цахимаар буюу банкны ажилтны оролцоогүй хийгдсэн байна.

Бид 2017 оноос хойш ХасБанкны данс хооронд хийгдэх гүйлгээний шимтгэлийг 0 болгосон ба 2022 онд нийт 1.3 тэрбум төгрөгийн шимтгэлийн хэмнэлтийг харилцагчдадаа үзүүлсэн байна.



Дижитал хэрэглэгч

▲ 26%

Гүйлгээний тоо

▲ 86%

Төлбөрийн карт

"FIFA World Cup Qatar 2022" Хөлбөмбөгийн ДАШТ-д зориулсан тусгай загвар бүхий ВИЗА картыг зах зээлд нэвтрүүлж, тус тэмцээний үеэр харилцагчдаа зөвхөн дижитал банкаар захиалахаар санал болгон тус карт эзэмшигчдэдээ зориулсан #БЭЛЭГЛЭЕ аяныг амжилттай зохион байгуулав.



ХасБанкны төлбөрийн карт эзэмшигч хүн бүрийг урамшуулах, хамтран ажиллаж буй бизнесийн байгууллагуудын бизнесийг дэмжих зорилгоор тухайлбал Ази Фарма эмийн сангуудаар явагдсан #Ядаргааг_Ялья дархлаажуулалтын аян зэрэг 7 удаагийн аяныг 30 мерчанттай хамтарч буцаан олголт бүхий урамшуулалт аяныг тайлант хугацаанд зохион байгууллаа. Үүний үр дүнд өмнөх онтой харьцуулахад нийт картын тоо 9%, картын гүйлгээний тоо 22% өслөө.

Нийт картын тоо

▲ 9%

Картын гүйлгээ

▲ 22%



Мерчант

Төлбөр тооцооны дэд бүтэц, сүлжээг өргөтгөх, банкны үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор ПОС төхөөрөмжийн тоог тогтмол нэмэгдүүлж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд харилцагч мерчант байгууллагын тоо 45%-аар, ПОС төхөөрөмжийн тоо 42%-аар тус тус өссөн бөгөөд гүйлгээний шимтгэлийн орлого өмнөх онтой харьцуулахад 14%-аар өссөн байна.

Өнгөрөгч 2022 он цар тахлын дараах бизнесийн идэвхжил нэмэгдэж, нөхцөл байдал сайжирсан хэдий ч тодорхой бус байдал хэвээр хадгалагдсан жил байлаа.

БНХАУ-ын “тэг ковид” бодлого хэвээр хадгалагдсан нь ложистик, олон улсын тээвэр зуучлалын салбарт хүндрэл учруулсан хэвээр байсан бол дэлхий нийтээр ажиглагдсан үнийн өсөлт, инфляц, гадаад валютын ханшийн өсөлт зэрэг нь бизнесүүдэд хүндрэл учруулсаар байна. Бизнесүүд бараа, материал татаж авахад 2-3 дахин илүү хугацаа зарцуулахын зэрэгцээ ханшийн өсөлтөөр илүү дүнгээр худалдан авалт хийх болсон нь эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг огцом нэмэгдүүллээ.

Корпорейт зээлийн багц
429.0 тэрбум.₮

Чанаргүй, анхаарал татсан багц
31% ▼

Корпорейт зээлийн багц 2022 онд 429.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос даруй 29.5 хувиар өссөн бол анхаарал татсан болон чанаргүй зээлийн багц 31 хувиар буурч, багцын оновчтой удирдлагын стратеги амжилттай хэрэгжиж байна.

2022 онд системийн ач холбогдол бүхий банкнуудад хийгдсэн 2 дахь удаагийн Активын чанарын үнэлгээгээр ХасБанкны корпорейт зээлийн багц өндрөөр үнэлэгдэж, банкны системд зээлийн багцын чанараар дахин тэргүүлсэн жил боллоо.

Худалдааны санхүүжилт, гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаанд сорилт ихтэй жил болж өнгөрлөө. Олон улсын хориг арга хэмжээний нөлөөгөөр гадаад төлбөр тооцоонд тавих хяналт хэд дахин нэмэгдэж, зарим тохиолдолд корреспондент банкнууд төлбөр гүйцэтгэхээс татгалзах, зарим төрлийн гүйлгээг царцаах хүртэл хүндрэлүүд гарсан. Энэхүү хүндрэлтэй нөхцөл байдлыг чадварлаг ажилтнуудын идэвхтэй ажиллагаа, корреспондент банкны өргөн сүлжээг ашиглан амжилттай даван туулж, шимтгэлийн орлогын хэмжээг өмнөх оны түвшинд хадгалж чадлаа.

ХасЛизинг™ нь 2021 оны 11 дүгээр сарыг хүртэл ХасБанкны толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн охин компани байсан бол группийн бүтцийн өөрчлөлтийн хүрээнд 2021 оны 11 дүгээр сараас эхлэн компанийн тухай хуулийн 20-р зүйлийн дагуу ХасБанктай нэгдэн, ХасБанкны Лизингийн газар болж үйл ажиллагаагаа явуулж байна.

Лизингийн газар нь дэлхийд нэр хүнд бүхий автомашин, техник тоног төхөөрөмжийг Монгол Улсад албан ёсоор борлуулдаг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж иргэд, ААН байгууллагад санхүүгийн түрээсээр хурдан шуурхай, нэмэлт барьцаагүйгээр олгодог билээ. Харилцагчдын хувьд дэвшилтэт технологи бүхий, орчин үеийн шинэ автомашин, техник хэрэгслийг санхүүгийн түрээсээр авч, үйл ажиллагаандаа ашиглан, урт хугацаанд хэсэгчлэн төлөх боломжтой болж байгаа юм.

Хэдийгээр 2022 онд тээвэр логистикийн хүндрэлийн улмаас санхүүгийн түрээсээр олгох шинэ автомашин, техникийн хангалт, хүрэлцээ дутмаг байсан ч бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай нягт хамтран ажилласны үр дүнд 2022 оны эцсийн байдлаар санхүүгийн түрээсийн нийт багц 223 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 13.5%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Цаашдаа бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагааг улам өргөжүүлж, шинэ автомашин, техник хэрэгслийн санхүүгийн түрээсийн үйлчилгээг өргөжүүлэхийн зэрэгцээ хуучин автомашины зээл, зорилтот байршил дахь орон сууцны зээл, автомашины засвар үйлчилгээнд зориулсан тусгай нөхцөл бүхий кредит карт зэрэг үйлчилгээг шинээр нэвтрүүлэн ажиллаж байна.

Зах зээлд эрэлттэй, бизнесийн олон салбарт ашиглагдаж, түргэн борлогдох чадвартай сайн шинэ хөрөнгийг албан ёсны нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж харилцагчдад санхүүгийн түрээсээр олгож байгаа нь багцын чанарыг амжилттай удирдах гол хүчин зүйл юм. Харилцагчдын үйл ажиллагаа явуулж буй бизнесийн салбар бүрд тохируулан санхүүгийн түрээсээр олгосон хөрөнгийн төвлөрлийг оновчтой удирдсанаар, чанаргүй лизингийн багцын нийт багцад эзлэх хувийг 1%-аас бага түвшинд тогтвортой удирдан ажиллаж байна.

Шинэ Монгол Харумафүжи



Шинэ Монгол Харумафүжи сургуулийг анх төсөл эхэлсэн 2017 оноос эхлэн ХасБанк санхүүжүүлж ирсэн. Тайлант жилд төслийн сүүлийн шатны барилгын ажилд зориулан 6.0 тэрбум төгрөгийн санхүүжилт хийснээр сургуулийн цогцолбор бүхэлдээ ашиглалтад орлоо.

Төсөл нь 23,040 м2 талбай бүхий хичээлийн байр, биеийн тамирын цогцолбор, номын сан, урлагийн болон технологийн танхимаас бүрдэх цогц барилга юм. Барилгад дулаан алдагдал багатай цонх, фасад суурилагдсанаас гадна дулааныг эргүүлэн ашиглах рекуператорын систем, нарны зайн системийг суурилуулж өгснөөр эрчим хүчний хэмнэлт 47 хувьд хүрч, ногоон барилгын шаардлагыг бүрэн хангах төсөл болж чадлаа.

Шинэ Монгол Харумафүжи сургууль нь 1,140 сурагч, 65 багш, 30 гаруй ажилтантайгаар сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үйл ажиллагаа эхэлснээс хойш 2 удаагийн төгсөлтөө амжилттай хийгээд байна.

МСМ Групп ХХК

ХасБанк нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа нэр хүнд бүхий бүх бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай нягт хамтран ажилладаг бөгөөд тэдгээрийн нэг нь МСМ Групп ХХК билээ.

2022 оны хувьд олон улсын тээвэрлэлт, логистикийн нөхцөл байдлын улмаас Бэлтгэн нийлүүлэгч байгууллагын худалдан борлуулах техник хэрэгслийн татан авалт удааширсан, саатсан хүнд жил байсан ч ХасБанк болон МСМ Групп ХХК-ийн сайн хамтын ажиллагааны үр дүнд 40 орчим тэрбум төгрөгийн техникийг санхүүгийн түрээсээр амжилттай борлуулсан байна.

Мөн дэлхий нийтээр байгаль орчинд ээлтэй эрчим хүч болон түлшний зарцуулалт багатай автомашин, техник хэрэгслийн эрэлт нэмэгдэж буй энэ үед МСМ Групп ХХК нь бүрэн цахилгаан-эко BYD брэндийг Монгол Улсад албан ёсоор борлуулж эхэлсэн. ХасБанк нь нийгмийн хариуцлагын хүрээнд эко машины санхүүгийн түрээсийг МСМ Групп ХХК-тай хамтран 2022 онд зах зээлд нэвтрүүлэн нийт 5 тэрбум орчим төгрөгийн санхүүжилт харилцагчдад хийгээд байна.





Ногоон санхүүжилт

Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй ногоон бизнес, эко хэрэглээг дэмжих эко хэрэглээний болон хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

ХасБанк 2013 оноос хойш

2,319,431 тонн

CO₂ -той тэнцэх хэмжээний хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан.

Энэ нь

167,104,081

ширхэг шилмүүст болон навчит мод тарьж **10 жил** ургуулсантай ижил үр дүн юм.

Нэг га-д

300 мод

тарьсан гэвэл **167,104,081** ширхэг мод нь Улаанбаатар хотоос **1.2** дахин том газрыг бүрхэнэ.

ХасБанк НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (UNFCCC)-ийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, нөлөөллийг сааруулахад зориулж хөгжингүй орнуудаас хөгжиж буй орнуудад олгох санхүүжилтийн гол механизм болох Уур амьсгалын ногоон сан (УАНС)-ийн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллагаар 2016 онд магадлан итгэмжлэгдсэн Монгол Улсын анхны арилжааны банк төдийгүй хөгжиж буй орнууд дунд УАНС-аас магадлан итгэмжлэл авсан анхны хувийн хэвшлийн байгууллага болж байв. УАНС-аас магадлан итгэмжлэлийг 5 жилийн хугацаатай олгодог ба 2022 онд Уур Амьсгалын Ногоон сангийн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллагаар 2 дахь удаагаа дахин магадлан итгэмжлэгдэв.

УАНС-ийн магадлан итгэмжлэлийн эхний 5 жилд буюу 2017-2021 оны хооронд тус сангаар нийт 4 санхүүжилтийн хөтөлбөр, чадавх бэхжүүлэх техник туслалцааны хүрээнд бэлэн байдлын дэмжлэгийн 3 төсөл, төсөл хөгжүүлэх техник туслалцааны 2 төсөл, нийтдээ 9 төсөл хөтөлбөрийг амжилттай батлуулан хэрэгжүүлээд байна.

Тогтвортой санхүүжилт

2022 онд Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөр, Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажилласнаас гадна “Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашиг” хэмээх эрхэм зорилгынхоо хүрээнд Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамтай хамтран өрх, аж ахуйн нэгжүүдэд хүүгийн татаастай хөнгөлөлттэй ногоон зээлийг улс орон даяар олгож, өнөөгийн байгаль орчны тулгамдсан асуудал болох агаар, хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн 34 төрлийн технологийг санхүүжүүллээ.

2022 оны эцсийн байдлаар Тогтвортой санхүүжилтийн хүрээнд ХасБанк нийт 2,319,431 тонн хүлэмжийн хийг бодитойгоор бууруулаад байна.

Карбоны санхүүжилт

ХасБанк нь Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийн хүрээнд карбон кредитийг НҮБ-ын Цэвэр хөгжлийн механизм болон Карбоны сайн дурын зах зээлд бүртгүүлэн нөхөн олговор хүлээн авах ажлыг “МикроЭнержи Кредит” байгууллагатай үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Карбоны санхүүжилтийн хүрээнд хийгдсэн онцлох ажил:

- 2021-2022: Цэвэр хөгжлийн механизмд бүртгэлтэй байсан 150,086 карбон кредитийг карбоны сайн дурын зах зээлд шилжүүлэн бүртгүүлж, сайн дурын зах зээл дээр худалдах ажлыг эхлүүлээ.

Хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд



Хүлэмжийн хийг бууруулах жижиг дунд бизнесийн зээлийн хөтөлбөр



Монголын Ногоон Санхүүжилтийн Корпораци



Эрчим хүчний хэмнэлтийн даатгалын механизм боловсруулах төсөл



Сэргээгдэх эрчим хүчний хөтөлбөр



Үндэсний эрх бүхий байгууллага болон үндэсний зохицуулагчийн чадавхи бэхжүүлэх төсөл



Монголын ногоон санхүүжилтийн корпорац төсөл хөгжүүлэх дэмжлэг



Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөр



Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан шинэчлэх хөтөлбөр



Мини грид/офф грид халаалтын бие даасан шийдэл” төсөл

+35 тэрбум төгрөг

Сүүлийн 5 жилд мэдээллийн технологи, түүний аюулгүй байдалд оруулсан хөрөнгө оруулалт.

Банкны үйлчилгээг харилцагчдад хүртээмжтэй, хялбар бөгөөд зардал багатай хүргэх зорилгоор мэдээллийн технологи, дэд бүтэц, аюулгүй байдалд оруулсан хөрөнгө оруулалтын дүнд банкны нийт гүйлгээний 97% нь дижитал сувгаар хийгдэж, зээл авах, данс нээх, карт захиалахын тулд банк руу явах шаардлагагүй болсон.

Мэдээллийн технологи

Банкны үндсэн систем



Дэлхийн мэдээллийн технологийн салбарт тэргүүлэгч Infosys компанийн Finacle үндсэн систем.

Дижитал банкны платформ



Дижитал банкны чиглэлээр дэлхийд тэргүүлэгч IT компаниас 4-т жагсдаг Ilexceed компанийн Appzillon платформ.

Нээлттэй банк (open banking)



Бид fintech бизнесүүдийг дэмжин, системээ нээлттэй API-аар дамжуулан гуравдагч талын үйлчилгээ үзүүлэгчидтэй холбон хамтран ажиллаж байна.

Мэдээллийн аюулгүй байдал



мэдээллийн аюулгүй байдлын олон улсын ISO 27001 стандартыг Банкны салбартаа анхлан нэвтрүүлж, мөрдөн ажиллаж байна.

Дата төв



Олон улсын Tier 2 стандарт шаардлагыг бүрэн хангасан дата төвтэй.

Картын систем



Төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын PCI DSS стандартын шаардлагыг бүрэн хангасан.

Лицензтэй программ хангамж



Нийгмийн хариуцлага



Байгаль орчин



2022 онд “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөний Баруун салаа, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Зайсангийн аманд мод тарьлаа. Мөн ТЭРБУМ МОД санд өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжилт олгон ажиллаж байна.



Боловсрол

2009 оноос эхлэн Дэлхийн Эмэгтэйчүүдийн Банктай хамтран 14-18 насны сурагч хүүхдүүдэд санхүүгийн боловсрол олгох зорилгоор нийт 13 модультэй “Тэмүүлэл” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн нь 2017 оноос ЕБС-ын хичээлийн хөтөлбөр албан ёсоор орсон.

Мөн 8-13 насны хүүхдүүдэд нийгэм, санхүүгийн боловсрол олгох “Афлатон” хөтөлбөрийг хот, хөдөөгийн сургуулиудад хэрэгжүүлснээр Монгол хүүхдүүд санхүүгийн боловсролтой, бие даасан иргэн болон төлөвших эхлэлийг тавьсан.



ХасБанкны ТУЗ-ийн гишүүн асан Питер Морроугийн нэрэмжит оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг 7 дахь жилдээ амжилттай зохион байгуулж, Банк, санхүү, эдийн засаг, бизнесийн удирдлага, дата аналитик, мэдээллийн технологийн чиглэлээр амжилттай суралцаж буй оюутнуудыг сургалтын төлбөрийг олгож байна.

Мэдээллийн технологийн чиглэлээр суралцаж буй оюутан залууст банкнаас ажлын гараагаа эхлүүлэх боломжийг олгох зорилготой “Цалинтай оюутан” хөтөлбөрийг 3 дахь жилдээ зохион байгуулж, шалгарсан оюутнууд цалинтай дадлага хийж байна.



Спорт

Биеийн тамир, спортыг дэлгэрүүлэх, түүн дотроос багийн спортыг хөгжүүлэх зорилгоор сагсан бөмбөгийн “Хасын хүлэгүүд” багийг 2004 онд байгуулан тасралтгүй 19 жил дэмжиж байна. Хасын хүлэгүүд баг Монголын сагсан бөмбөгийн дээд лигийн 7 удаагийн аварга болсон.



Бээжин 2022 өвлийн олимпын наадамд оролцож буй тамирчдаа дэмжиж, Монголын Үндэсний Олимпын Хорооны албан ёсны түншээр хамтран ажиллалаа.

“Мэргэн академи” хүүхдийн хоккейн клубтэй хамтран ажиллаж, хоккейн спортоор хичээллэгч хүүхэд багачуудыг дэмжиж байна.



Шайбтай хоккейн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнийг 2023 онд Монгол Улсад анх удаа зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллалаа.



соёл, Урлаг



Бүгд Найрамдах Франц Улсад зохион байгуулагдсан Монгол соёлын өдрүүд болон Монгол Улс ЮНЕСКО-д элссэний 60 жилийн ойд зориулж ЮНЕСКО-ийн төв байранд зохион байгуулагдсан МОНГОЛЫН САЙХАН ОРОН дижитал фото үзэсгэлэн дэмжиж хамтран ажилласан.



Харилцагчаа хамгаалах



ХасБанк Харилцагчийг хамгаалах ухаалаг хөдөлгөөнд нэгдэж, тус хөдөлгөөний 7 зарчим 99 шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан хэмээн батламжлагдсан арилжааны банк бөгөөд энэ хүрээнд Ил тод, нээлттэй байх, Харилцагчийг өрийн дарамтаас хамгаалах, Харилцагчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, Харилцагчийн гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх зэрэг зарчмуудыг мөрддөг.

Макро эдийн засгийн төлөв


Монгол улсын эдийн засаг 2022 онд 4.8%-иар өссөн байна. БНХАУ-ын Ковид-19 цар тахлын эсрэг хатуу хориг арга хэмжээнүүд, ОХУ болон Украйны хооронд үүссэн геополитикийн асуудал зэрэг томоохон сорилтуудтай нүүр тулгарсан хэдий ч тус онд Монгол улсын эдийн засаг өмнөх оны өсөлтийг давж гарлаа.

Оны эхний улиралд БНХАУ-ын хилийн нэвтрүүлэлтийн хязгаарлалтаас үүдэн уул уурхайн түүхий эдийн тэр дундаа нүүрсний экспорт өмнөх оныхоо мөн үеэс 63%-иар буурч улмаар эдийн засгийн өсөлт -3.9%-д хүрээд байсан бол хоёрдугаар улирлаас хил дээрх гацаа аажим шийдэгдэж, экспорт нэмэгдэж эхэлснээр оны эцэс гэхэд 31.8 сая тон нүүрс экспортолсон нь өмнөх оноос 97%-иар өссөн үзүүлэлт байв.

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон эдийн засгийн өсөлтийг эдийн засгийн секторуудаар задалж харвал уул уурхайгаас бусад бүх салбарууд эерэг нөлөөг үзүүлсэн бол уул уурхайн салбар эдийн засгийн өсөлтийг бууруулах чиглэлд нөлөөлсөн байна. Үйлчилгээ (бөөний худалдаа, тээвэр, мэдээлэл холбоо болон бусад үйлчилгээ) болон хөдөө аж ахуйн салбарын өсөлт нийт эдийн засгийн өсөлтөд 2.6 болон 1.7 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн нь бусад салбаруудаас хамгийн өндөр байв.

Инфляц

Хэдийгээр оны сүүлийн хагаст инфляц бага зэрэг буурах хандлага ажиглагдаж байгаа хэдий ч оны эцсийн байдлаар улсын инфляц 13.2%-д хүрч төв банкны зорилтот түвшнээс даруй 7.2 нэгж хувиар өндөр гарав. Инфляцыг бүрэлдэхүүнээр задалж харвал хувцас бөс бараа болон гутлын бүлгийн үнийн өсөлт 18.5%, хүнсний бараа ундаа усны бүлгийн үнэ 15.4%, орон сууц, ус, цахилгаан болон бусд түлшний бүлгийн үнийн өсөлт 15.4%, эм тариа эмнэлгийн үйлчилгээний үнэ 17.4%-иар тус тус өссөн нь хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн инфляц 13.2% гарахад голлон нөлөөлсөн.




Эдийн засгийн өсөлт, салбаруудын оруулсан хувь нэмэр

2022 онд цар тахлын дараах эдийн засгийн сэргэлт үргэлжилж, тэр дундаа худалдаа, үйлчилгээний салбарууд бүрэн сэргэсэн нь эдийн засгийн өсөлт 4.8%-д хүрч тэлэхэд томоохон нөлөөг үзүүлсэн. Тодруулбал дотоодын бөөний болон жижиглэн худалдааны нийт борлуулалт өмнөх оноос 29.5%-иар, барааны импорт 27.1%-иар тус тус нэмэгдсэн байна. Түүнчлэн зочид буудлын салбар нийт орлого 54.2%-иар, нийтийн хоолны салбар 46.4%-иар тус тус өсчээ.

Цар тахлын үеийн мөнгөний тэлэх бодлого, нийлүүлэлтийн гинжин хэлхээний тасалдал зэргээс шалтгаалан 2021 оны дунд үеэс дэлхий даяар инфляц хурдтай нэмэгдэж эхэлсний дээр 2022 онд үүссэн ОХУ болон Украйны хооронд үүссэн геополитикийн асуудал нь инфляцыг улам өдөөх шалтгаан болов.


Монгол улсын хувьд ч бусад улс орнуудын нэгэн адил өндөр инфляцыг бууруулах нь эдийн засгийн гол сорилт болсон хэвээр байна. 2022 оны турш инфляц төв банкны зорилтот түвшингээс харьцангуй дээр буюу 13.2 –с 16.9% хооронд байв. Өндөр инфляц нь иргэдийн бодит орлогыг бууруулах замаар өрхийн санхүүд сөргөөр нөлөөлдөг. Цаашлаад банкны секторт иргэдийн зээлийн чанар муудах эрсдэлийг бий болгож байна.



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, (2015 оны суурь үнээр)

Худалдааны тэнцэл (тэрбум.доллар)

2022 онд нийт экспорт 35.7%-иар өсч 12.5 тэрбум ам.долларт, нийт импорт 27.2%-иар өсч 8.7 тэрбум ам.долларт тус тус хүрснээр гадаад худалдааны тэнцэл 3.8 тэрбум ам.долларын ашигтай гарсан нь өмнөх оноос 1.4 тэрбум ам.доллараар өссөн үзүүлэлт байв. Экспортын өсөлтөд нүүрсний экспортын өсөлт голлон нөлөөлсөн бол импортын өсөлтөд дизел түлш, автобензин болон суудлын машины ипортын өсөлт голлон нөлөөлсөн.




Эх сурвалж: Монголбанк

Макро эдийн засгийн төлөв

ГВАН болон долларын ханш

Хэдийгээр гадаад худалдааны тэнцэл 3.8 тэрбум ам.долларын ашигтай гарсан хэдий ч төлбөрийн тэнцэл оны эцсээр 0.7 тэрбум ам.доллар тэр дундаа урсгал дансны алдагдал 2.8 тэрбум ам.долларт хүрсэн нь гадаад валютын албан нөөц (ГВАН) 2022 онд 966 сая ам.доллараар буурахад нөлөөллөө. Төлбөрийн тэнцлийн хүндрэлтэй нөхцөл байдалд ам.долларын ханш төгрөгийн эсрэг жилийн дотор 20.9%-иар чангарсан нь 2016 оноос хойш хамгийн өндөр өсөлт болов.



Эх сурвалж: Монголбанк


Банкны салбар

Монгол улсад 12 арилжааны банк үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тэдний нийт хөрөнгийн хэмжээ 45.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 12.3%-иар өссөн бол өөрийн хөрөнгө 24.2%-иар нэмэгдэж 5.0 их наяд төгрөгт хүрсэн байна. Түүнчлэн арилжааны банкуудын ашигт ажиллагаа нэмэгдэж системийн хэмжээнд тухайн оны ашиг 1.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос даруй 1.9 дахин нэмэгдсэн нь өөрийн хөрөнгө ийнхүү өсөхөд нөлөөллөө. Банкны салбарын шинэчлэлтэй холбоотой оны сүүлийн хагаст системд нөлөө бүхий хоёр банк хувьцаат компани болж олон нийтэд хувьцаагаа санал болгож амжилттай IPO хийлээ. Ирэх 2023 оны эхний хагаст багтан системд нөлөө бүхий бусад гурван банк олон нийтэд нээлттэй компани болж IPO хийхээр хүлээгдэж байна.

Банкны салбарын иргэд, аж ахуй нэгжид олгосон зээлийн үлдэгдлийн хэмжээ 2022 онд 6.2%-иар өсч 22.2 их наяд төгрөгт хүрлээ. 2021 онд 20.6%-д хүрээд байсан зээлийн өсөлт ийнхүү буурсан нь цар тахлын үед авч хэрэгжүүлж байсан хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүд дуусгавар болсонтой холбоотойгоос гадна 2022 оны турш төв банк мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлсэн нь банкуудын зээл олголтод мөн нөлөөлсөн. Тайлант онд хувийн байгууллагад олгосон зээлийн үлдэгдэл 3.3%-иар өссөн бол иргэдэдэд олгосон зээлийн үлдэгдэл 11.2%-иар тус тус өсчээ.

Инфляцтай тэмцэх, дотоод валютын өгөөжийг өсгөх зорилгоор Монголбанк 2022 онд 5 удаагийн мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр бодлогын хүүг 6%-с 13%-д хүргэж 7.0 нэгж хувиар нэмэгдүүлсэн нь зээл, хадгаламжийн хүү өсөхөд нөлөөллөө. 2022 оны 12 дугаар сарын байдлаар төгрөгийн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 15.7% болж өмнөх жилийн мөн үеэс 1.4 нэгж хувиар өссөн бол, гадаад валютын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 10.1% болж өмнөх оны мөн үеэс 2.4 нэгж хувиар өссөн. Харин шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү 2022 оны 12 дугаар сарын байдлаар 10.5% болж өмнөх оны мөн үеэс 5.2 нэгж хувиар өссөн бол гадаад валютын хадгаламжийн хүү 0.07 нэгж хувиар буурч 3.4%-д хүрчээ.


Банкны салбарын зээлийн хэмжээ болон зээлийн хүү



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Банкны салбарын харилцах, хадгаламж


Харилцагчдаас татсан нийт харилцах хадгаламжийн үлдэгдэл тайлант оны эцсээр 27.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 7.5%-иар өссөн. Ам.долларын ханш төгрөгийн эсрэг огцом чангарсан нь банкны секторт долларжих үзэгдлийг бий болгосноор төгрөгийн харилцах хадгаламж 7.9%-иар буурч, гадаад валютын харилцах хадгаламж 30.2%-иар өсөхөд нөлөөллөө.



Эх сурвалж: Монголбанк

Банкны салбарын чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл, нийт зээлд эзлэх хувиар

Банкны салбарын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2022 оны 12 дугаар сарын байдлаар 9.0%-д хүрч өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар буурсан бол хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзлэх хувь 5.1% болж 0.6 нэгж хувиар өсчээ.



Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн үр дүн, удирдлага

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтын биелэлт

Банк нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол ханган, хяналт тавин ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүдийн үр дүнд ХасБанкны санхүүгийн нөхцөл байдал, балансын чанар, өөрийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт эрс сайжирч чадлаа. Тайлант жилийн байдлаар нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт Монголбанкны тогтоосон байвал зохих түвшнээс харьцангуй өндөр (1 дахин) түвшинд байгаа нь ХасБанк найдвартай байдлыг улам бүр илтгэж байна.

Тусгайлан өөрөөр заагаагүй бол хувиар (%) илэрхийлэв (тухайн оны эцсийн үзүүлэлт)	2020	2021	2022
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа >9%*	16.9%	17.4%	20.1%
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа > 12%	17.4%	17.4%	20.1%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт >25%	54.9%	44.3%	41.1%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) +/-15%	-1.8%	-1.1%	6.2%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар) +/-40%	-4.2%	-2.2%	6.9%
Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа** <300%	77.2%	72.8%	66.6%
Үндсэн хөрөнгө нийт хөрөнгийн харьцаа <8%	2.5%	1.7%	1.7%
Хадгаламжийн төвлөрлийн харьцаа*** <25%	7.0%	7.1%	7.7%

* 2022 оны 1 сарын 1-нээс эхлэн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлт ХасБанкны хувьд 9+(нөөц шаардлага 3.5%) болсон.

** Өөрийн хөрөнгийн 5 хувиас дээш дүнтэй активыг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа.

*** Хамгийн том 10 харилцагчийн харилцах, хадгаламжийн нийлбэрийн нийт актив хөрөнгөд эзлэх хувь.

Мөн банкны тухай хуульд заасны дагуу ХасБанк нь холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн харьцаа үзүүлэлтийг тогтмол ханган ажиллаж байна.

Тусгайлан өөрөөр заагаагүй бол хувиар (%) илэрхийлэв (тухайн оны эцсийн үзүүлэлт)	2020	2021	2022
Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй):			
Банкны нийт хувьцаа эзэмшигчид	0.0%	0.0%	0.0%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.2%	0.1%	0.1%
Банкны бусад холбогдох этгээд	1.8%	1.8%	1.6%
Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй):			
Банкны нийт хувьцаа эзэмшигчид	0.0%	0.0%	0.0%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.5%	0.4%	0.3%
Банкны бусад холбогдох этгээд	3.6%	4.5%	3.8%

Санхүүгийн үр дүн, удирдлага


Санхүүгийн үр дүн

2021 болон 2022 онууд нь КОВИД19 цар тахлын үр нөлөөгөөр бизнес, эдийн засагт олон төрлийн хүндрэлүүд үүсгэж, Иргэд болон ААН-үүдэд ихээхэн сорилтуудыг дагуулж байсан. ХасБанк нь сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдийн үр дүнд Банкны балансын бүтэц болон ашигт ажиллагаагаа сайжруулан ажилласан.


Цэвэр ашиг
Тэрбум төгрөг



Өөрийн хөрөнгийн өгөөж
%



Нийт хөрөнгийн өгөөж
%



2022 оны татварын дараах цэвэр ашиг 105.8 тэрбум төгрөгт хүрч, өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 27.6%-д хүрсэн нь түүхэн өндөр үзүүлэлт юм. Ийнхүү ашигт ажиллагаа сайжирсан нь актив пассивын оновчтой бүтцийг бий болгож, цэвэр хүүгийн маржинг сайжирсантай шууд холбоотой юм. Үүнээс гадна 2022 оны хувьд хүүгийн бус орлогын өсөлт ашигт ажиллагаанд ихээхэн нөлөө үзүүлсэн. Банкны хүүгийн бус орлого нь валют арилжааны орлого, картын төлбөр тооцоо, олон улсын төлбөр тооцоо, гадаад худалдаа болон баталгаа, батлан даалтын орлого, бусад банкны үйлчилгээний орлогоос бүрддэг.

2022 он дотоод, гадаад валютын зах зээлийн хувьд ихээхэн хэлбэлзэлтэй, өндөр spread-тэй байсан нь тайлант жилд валют арилжааны орлого нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна. Мөн өнгөрсөн 5 жилд банкны картан дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалт, ПОС терминал сүлжээний өргөтгөл, АМТ тоо нэмэгдсэн зэргээс шалтгаалан картан цэвэр хураамж, шимтгэлийн дүн тогтвортой өсөж байна.


Валют арилжааны орлого
Тэрбум төгрөг



Картын, ПОС, АТМ-ын цэвэр орлого
Тэрбум төгрөг



Бусад шимтгэл, хураамжийн орлого
Тэрбум төгрөг



Банк 2019-2021 онуудад эрсдэлийн удирдлагын бодлогын өөрчлөлтийн дагуу активын чанараа сайжруулан ажилласан нь 2021, 2022 онуудад зээлийн эрсдэлийн сангийн зардлыг тогтвортой бага түвшинд удирдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Зээл, санхүүгийн түрээсийн нийт багц
Тэрбум төгрөг



Чанаргүй зээл, санхүүгийн түрээсийн үлдэгдэл
Тэрбум төгрөг




МБ-ны журмын дагуу байгуулсан зээлийн эрсдэлийн сан
Тэрбум төгрөг



Банкны баримтлан ажиллаж буй эрсдэлийн бодлогын дагуу шинээр зээл олгох стандарт, шаардлагыг нэмэгдүүлж, аливаа эрсдэл өндөр эдийн засгийн салбар, сегментэд олгох зээлийн хэмжээнд тодорхой хязгаарлалтуудыг тавьж (concentration and industry limit), чанаргүй зээлийг эрт илрүүлж, холбогдох эрсдэлийн санг хангалттай түвшинд (risk coverage 100%) байгуулж ажилладаг.

Нийт Актив
Тэрбум төгрөг



Зээлийн барьцаанд хураагдсан хөрөнгийн үлдэгдэл (ӨБҮХХ)
Тэрбум төгрөг



МБ-ны журмын дагуу байгуулсан ӨБҮХХ-ийн сан
Тэрбум төгрөг




Банк нь төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа тогтвортой өндөрт ханган ажиллах зорилгоор хөрвөх чадвар өндөртэй активт илүүдэл эх үүсвэрээ байршуулан ажилладаг. 2017 оноос эхлэн Засгийн Газрын дотоодын мөнгөний захад гаргах үнэт цаас хязгаарлагдсанаар арилжааны банкнууд зөвхөн Төвбанкны үнэт цаас (ТБҮЦ) худалдан авч байна. 2022 оны эцсийн байдлаар Банкны эзэмшиж буй ТБҮЦ-ны хэмжээ 577.2 тэрбум төгрөг байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа
%



ТБҮЦ
Тэрбум төгрөг



ТБҮЦ-аас бусад түргэн борлогдох цэвэр актив буюу бэлэн мөнгө түүнтэй адилтгах актив
Тэрбум төгрөг



Эрсдэлийн удирдлага

Банкны эрсдэлийн удирдлагын үндсэн чиг үүрэг нь санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлийг зохистой түвшинд удирдахын зэрэгцээ, бизнесийн нэгжүүдэд стратеги, төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэхэд оршино.

Банкны эрсдэлийн удирдлагын аргачлал, чиг үүргийн тодорхойлолт нь Хамгаалалтын гурван бүсийн зарчимд дараах байдлаар суурилсан.

Үүнд:

- Хамгаалалтын нэгдүгээр бүс нь эрсдэлийг хариуцах эзэн нь байх бөгөөд өөрийн үйл ажиллагаан дахь өдөр тутмын эрсдэлийг удирдана.
- Хамгаалалтын хоёрдугаар бүс нь эрсдэлийн удирдлагын тогтолцоо, бодлого, журмыг боловсруулж, батлуулж, тэдгээрийн хэрэгжилт, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээ, хязгаар үзүүлэлтүүдэд хяналт тавьж ажиллана. Мөн хамгаалалтын нэгдүгээр бүсийн хяналтын үйл ажиллагаанд хяналт тавихаас гадна тэдгээрийн үйл ажиллагаанд байнгын дэмжлэг үзүүлж ажиллана.
- Хамгаалалтын гуравдугаар бүс нь эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлж, хамгаалалтын нэг, хоёрдугаар бүсийн эрсдэлийг үр дүнтэй удирдаж буй байдалд хараат бус үнэлэлтийг өгч ажиллана.

Эрсдэлийн засаглал

Төлөөлөн удирдах зөвлөл нь Банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг тогтоох, эрсдэлийг үр дүнтэй удирдах бодлого, чиглэлийг батлах эрх бүхий этгээд юм. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн эрх хэмжээний хүрээнд эрсдэлийн удирдлага, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээний хэрэгжилтэнд хяналт тавьж, Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнадаг.

Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо болон Банкны Эрсдэл хариуцсан захирал нь эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хангаж ажиллах чиг үүрэгтэй.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийг удирдах үндсэн зарчим, бодлогын бичиг баримт болох Эрсдэлийн удирдлагын тогтолцооны бичиг баримтыг хянаж, баталдаг. Банкны Эрсдэлийн удирдлагын тогтолцооны бичиг баримтад хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:



Эрсдэл даах чадвар

зохицуулагч байгууллагын тавьсан хязгаарлалтуудын хүрээнд Банкны хүлээж чадах эрсдэлийн хэмжээг хэлнэ.



Хүлээн зөвшөөрөх эрсдэл

Банкны стратеги, бизнес төлөвлөгөөг биелүүлэхэд хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг хэлнэ.



Эрсдэлийн хязгаар

Банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхийн тулд тогтоосон эрсдэлийн болон багцын хязгаар үзүүлэлтүүдийг хэлнэ.

Зээлийн эрсдэлийн удирдлага

Банк нь зээлийн эрсдэлийг эзэлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаандаа биелүүлээгүйгээс шалтгаалан үүсэх алдагдлыг хүлээх эрсдэл гэж тодорхойлдог. Зээлийн багц нь Банкны активын томоохон хэсгийг бүрдүүлдэг тул зээл, зээлийн эрсдэл нь Банкны удирдах ёстой ач холбогдол бүхий томоохон эрсдэлүүдийн нэг юм.

Бид зээлийн эрсдэлийг удирдахад шаардагдах зээлийн зохистой бодлогуудыг тодорхойлж, зээл олголт, түүний дараах гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх байдлаар зээлийн эрсдэлийг удирдаж байна. Түүнчлэн зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор зээлийн эрсдэлийн удирдлага болон хяналтыг хэрэгжүүлснээр Банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон зээлийн эрсдэлийн хязгаар үзүүлэлтүүд болон Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг биелүүлэн ажиллаж байна.

Үйл ажиллагааны эрсдэл

Банк нь хүний хүчин зүйл, дотоод процесс, мэдээллийн технологийн алдаа, доголдол болон гадна орчны нөлөөллийн улмаас өдөр тутамдаа үйл ажиллагааны эрсдэлтэй тулгардаг ба тэрхүү эрсдэлийг цаг тухайд нь илрүүлэх, үнэлэх, зөв зохистой хяналтыг хэрэгжүүлснээр хүлээн зөвшөөрөх түвшинд удирдан ажилладаг.

Бизнесийн нэгжүүд нь өөрийн хариуцсан процессуудыг Банкны шинэ үндсэн системийн шинэчлэлтэй холбоотой өөрчлөлтүүдийн шинэчилж, эрсдэлийн үнэлгээг Үйл ажиллагааны эрсдэл хариуцсан нэгжийн заавар, зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэж байна.

Түүнчлэн, үйл ажиллагааны эрсдэлд илүү анхаарал хандуулж, аливаа эрсдэл давтагдан гарахаас сэргийлэхээр авч буй арга хэмжээг сайжруулах зорилготойгоор Банкны санхүүгийн бус эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг хянан чангатгав.

Зохицуулалт

2020 онд ФАТФ нь виртуал хөрөнгө болон Виртуал Хөрөнгийн Үйлчилгээ Үзүүлэгч (ВХҮҮ) нарт чиглэсэн эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх талаарх зөвлөмжийг шинэчилсэн бөгөөд Монгол Улсын Их Хурал 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг баталлаа. Түүнчлэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг Монгол улсын хэмжээнд үнэлж, холбогдох хууль журмуудыг шинэчлэн боловсруулж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, болзошгүй санхүүгийн эрсдэлээс ард иргэдийг сэрэмжлүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль 2013 оны тавдугаар сарын 13-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2022 онд дөрвөн удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Уг хуульд харилцагчийг таньж мэдэх ажиллагаа болон гүйлгээний тусгай хяналтад тавигдах шаардлага зэрэг тусгагдсан бөгөөд ВХҮҮ нар гүйлгээгээ Санхүүгийн Мэдээллийн Алба (СМА)-д тайлагнах шинэ үүргийг оруулсан байна. МУТСТ хууль болон зохицуулагч байгууллагаас гаргасан холбогдох дүрэм журамд гарсан өөрчлөлт нь ХасБанкны бодлого, журамд тухай бүр тусгагдаж, тогтмол шинэчлэгдэж байдаг болно.

Эрсдэлийн удирдлага

Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх нь

Банк нь санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрддөг бөгөөд үүнд санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, авлига ба хээл хахуультай тэмцэх, татвар төлөхөөс зайлсхийхтэй тэмцэх зэрэг зохицуулалтууд багтана.

Санхүүгийн системийг онолох гэмт хэрэгтнүүд технологийг улам боловсронгуйгаар ашиглаж байгаа нь биднээс санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэхэд чухлаар анхаарал хандуулахыг шаардаж байгаа бөгөөд энэ нь бид хянан нийцүүлэхийн тулд тасралтгүй хөгжиж байдаг гэсэн үг юм.

Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын хүрээнд Банк нь дараах үйл ажиллагаанд анхаарал хандуулан ажиллаж байна. Тухайлбал:

- Комплаенсийн багаа хөгжүүлж, зохицуулагч, хууль сахиулах байгууллага болон СМА-тай нягт хамтран ажиллах;
- Гүйлгээний хяналтын сайжруулсан систем зэрэг шинэ технологид хөрөнгө оруулах;
- Харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээ болон сувгийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг илүү сайн ойлгохын тулд эрсдэлийн үнэлгээний хэрэгсэл, өгөгдөл, үйл явцыг сайжруулах;
- Авлига, хээл хахууль болон Татвараас зайлсхийхийн эсрэг хяналтын тогтолцоог хөгжүүлэх;
- Санхүүгийн гэмт хэргийн олон нийтэд үзүүлэх нөлөөлөл, түүнийг хэрхэн илрүүлэх, таслан зогсооход чиглэсэн ажилтнуудад зориулсан сургалт болон мэдээлэл хүргэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах.

ОХУ-Украйн

ОХУ болон Украин улс хооронд үүсээд байгаа асуудлаас үүдэн Монгол улсад болон олон улсад мөрдөгдөж буй зарим дүрэм журам, шаардлагуудад гэнэтийн өөрчлөлт орсоор байгаа бөгөөд Банк түргэн шуурхай хариу арга хэмжээ авах шаардлагатай болсон. Манай комплаенсийн мэргэжилтнүүд холбогдох системүүдийг шинэчилж, төлбөр тооцоо болон харилцагчийн мэдээллийг хоригтой тулгахад өөрчлөлт оруулах ажлыг зохицуулж, бизнесийн нэгж бүр хурдацтай өөрчлөгдөж буй зохицуулалтын шаардлага, удирдамжийг мэдэж байх тал дээр нь анхаарал хандуулан, тогтмол мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Бид бодлого журам болон автоматжуулсан систем, хяналтыг хослуулан холбогдох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хэмжих, бууруулах, тайлагнах арга хэмжээ бүхий Комплаенсийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Банк нь мөн ажилтнууддаа хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтыг явуулж, магадлан шалгах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Комплаенсийн соёлыг сурталчлах шаардлагатай гэдэгт бид итгэдэг бөгөөд үүнийг манай Төлөөлөн Удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын багийн хамт олны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэн ажиллаж байна.

Комплаенс

Банкны Комплаенсийн функцийн эрхэм зорилго нь тогтвортой бизнесийн үйл ажиллагааг хангах, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор ХасБанкны Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын хүрээнд өндөр стандартын дагуу үйл ажиллагаа явуулж, дотоод болон гадаад түншлэлээр дамжуулан Банк, харилцагчид болон олон нийтийн харилцаанд эерэг үр дүнд хүрэхэд оршино.

Комплаенсийн эрсдэл гэдэг нь санхүүгийн салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын шаардлага, тухайн салбарын бизнесийн болон мэргэжлийн ёс зүйн стандартыг дагаж мөрдөөгүйгээс ХасБанк нь бизнесийн үйл ажиллагааг амжилттай явуулах боломжгүй болох эрсдэлийг хэлнэ. Үүнд, ялангуяа санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, залилан болон авлига, хээл хахуультай тэмцэх зохицуулалтууд орно.

Зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

Банк нь жил бүр Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооноос хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг Банкны бизнес төлөвлөгөө, стратегитэй уялдуулан шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг.

2022 онд зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэлийн үзүүлэлтүүдийг зохицуулагч байгууллагын шаардлага болон Банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний хүрээнд тогтмол хангаж ажиллалаа.

Банк нь хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хүрээнд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлтийг Монголбанкнаас тавьдаг зохистой харьцааны доод шаардлагыг бүрэн хангаж ажилласнаас гадна хөрвөх чадварын нөөц (liquidity buffer), богино хугацаат хөрвөх чадварын үзүүлэлт (short-term liquidity ratio), хөрвөх чадварын хүрэлцээний харьцаа (LCR), цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцаа (NSFR) зэрэг үзүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний хүрээнд удирдаж ажиллаа.

Хүүгийн эрсдэлийн удирдлагын хүрээнд Банкны хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий нийт актив пассивын зөрүү болон хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий байдлын шинжилгээг тогтмол хийж санхүүгийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны дагуу удирдаж ажилласан.

Тус хугацаанд Банк гадаад валютын позицийн Монголбанкны шаардлагыг бүрэн хангахаас гадна цэвэр нээлттэй позицийн ашиг, алдагдлын хэмжээг (Хамгийн Их Эрсдэл (Value-At-Risk)-ийн үнэлгээ) Банк хүлээн зөвшөөрөх хэмжээнд хангаж ажиллалаа.

Түүнчлэн өнөөгийн эдийн засгийн тодорхой бус байдал давамгайлсан бизнесийн орчинд шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, тохиолдож болзошгүй гэнэтийн хүндрэлт нөхцлүүдэд Банкны санхүүгийн байдал, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, хөрвөх чадварт үүсч болох нөлөөллийг тодорхойлох зорилгоор цочирлын тест (стресс тест)-ийн шинжилгээг тогтмол хийж ажиллаж байна.

Хүний нөөц

ХасБанкны хүний нөөцийн бодлого нь олон талт ур чадвар бүхий ажилтнуудаас бүрдэх ажил хэрэгч соёлыг дэмжих, гүйцэтгэлээс хамаарсан өрсөлдөхүйц цалин хөлс, урамшуулал олгох, ажилтнууд үзэл бодлоо нээлттэй, чөлөөтэй илэрхийлэх, шударгаар ажиллах, сурч хөгжих боломжоор хангах, эрүүл, аюулгүй, тав тухтай ажиллах орчинг бүрдүүлэхэд чиглэдэг.

ХасБанк нь 2022 оны эцсийн байдлаар нийт 1,143 идэвхтэй ажилтантай байсан бөгөөд ажилтнуудын дундаж нас 34.1, банкинд ажилласан дундаж хугацаа 7.6 жил байна.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах бодлогын хүрээнд нийт ажилтнуудын 62 хувь болон удирдах ажилтны 50 хувийг эмэгтэй ажилтнууд тус тус бүрдүүлж байна.

Статистик мэдээлэл




Цалин хөлс, хангамж, сайн сайхан оршихуй

Бид цалин хөлсийг шат дараатайгаар гүйцэтгэлээс хамааруулан нэмэгдүүлэх, гүйцэтгэлээс хамаарсан хувьсах цалингийн системийг хэрэгжүүлэхээс гадна богино болон урт хугацааны урамшууллын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

2022 онд гүйцэтгэлээс хамаарсан хувьсах цалингийн системийг хэрэгжүүлсэн бөгөөд, Салбар тооцооны төвийн нийт ажилтнуудыг (Салбарын захирал болон Туслах ажилтнуудаас бусад) энэхүү хувьсах цалингийн системд хамруулсан.

Сургалт хөгжил

Ажилтнуудынхаа ажил, мэргэжлийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх, тасралтгүй суралцагч байгууллагын соёлыг бэхжүүлэх зорилгоор олон улсын болон дотоодын олон төрлийн сургалт хөгжлийн хөтөлбөрүүдийг онлайн сургалтын программ болон танхимын сургалтуудаар дамжуулан хүргэдэг. Тухайлбал 2022 онд нийт 223,826 хүн/цагийн сургалтанд давхардсан тоогоор 2,702 ажилтныг хамрууллаа.



Багийн амжилт



Бид багийн спортыг дэмжин ажилтнуудынхаа чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх төрөл бүрийн спортын арга хэмжээг дэмжин ажилладаг бөгөөд 2022 онд манай хамт олон багийн спортын төрөлд бүх цаг үеийн дээд амжилтуудыг үзүүлсэн түүхэн жил байлаа.

Банк хоорондын заалны болон гадаа талбайн Хөлбөмбөгийн тэмцээний алтан медаль, Гар бөмбөгийн тэмцээний эмэгтэй болон эрэгтэй төрөлд хос алтан медаль, Сагсан бөмбөгийн тэмцээний эмэгтэй төрөлд мөнгөн медаль, эрэгтэй төрөлд хүрэл медаль, Ширээний теннисний тэмцээний мөнгөн медалийг тус тус хүртсэн.

Банкны засаглал

Нийтэд хувьцаа санал болгох бэлтгэл ажлын хүрээнд засаглалыг бататгах нь

Зохистой засаглал нь ХасБанкны байгууллагын соёл, үнэт зүйлсийн салшгүй хэсэг. 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль болон түүнд 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу бид 2023 онд нийтэд хувьцаа санал болгох зохистой засаглалын үйл ажиллагаагаа бататган сайжруулах арга хэмжээнүүдийг авч байна. Цаашид нийтэд хувьцаа нь арилжаалагддаг компани болох гэж буйн хувьд зохицуулагч байгууллага, хөрөнгө оруулагчдын илүү хатуу хяналт, шаардлагад нийцэн ажиллаж, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн мэдээллийн шаардлагуудыг хангаж чадахуйц зохистой компанийн засаглалтай байхад чиглэн ажиллаж ажиллаж байна.

Дэлхий дахинаа тархсан Ковид-19 цар тахлын нөлөө, түүнийг залган нүүрлэсэн хөрш зэргэлдээ улсын дайны хор уршиг манай Банкны сэргэлт, тогтвортой өсөлтийг үргэлжлүүлэн сорьсоор байна. Жилийн туршид ТУЗ, хувьцаа эзэмшигчид болон гүйцэтгэх удирдлагаас цар тахал, дайн, олон улсын хамтын байгууллагуудын хориг арга хэмжээнээс үүдэлтэй хямралын нөхцөлд хариу арга хэмжээ авах, эдийн засаг бизнесийг сэргээх төлөвлөгөө хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан бөгөөд ингэхдээ байгууллагын урт хугацааны зорилт, хувьцаа эзэмшигчид болон бусад нэгдмэл сонирхолтой талуудын урт хугацааны ашиг сонирхлыг орхигдуулахгүй байхад анхаарч ажилласан.

Хувьцаа эзэмшигчид

- Нээлттэй хувьцаат компани болох бэлтгэл ажлыг бүхий л талаас хангах, хувьцааны үнэ цэнийг урт удаан хугацаанд хадгалах зорилгоор оновчтой шийдвэрүүд гарган ажилласан байна.

ТУЗ

- Цаашид өсөлтийг дэмжих болон хадгалах зорилгоор гүйцэтгэх удирдлагад дэмжлэг үзүүлж, оновчтой шийдвэрүүдийг цаг тухайд нь гаргаж ажилласан.
- Нээлттэй компани болоход шаардлагатай шийдвэрүүдийг цаг тухайд нь түргэн шуурхай гаргаж, ТУЗ-ийн дүн шинжилгээгээр хувьцаа эзэмшигчдийг хангаж ажиллав.

Гүйцэтгэх удирдлага

- Ирээдүйд амжилттайгаар хувьцаа гаргах зорилгоор санхүүгийн байр суурийг бататгах, активын чанарыг сайжруулахад анхаарч, хөрвөх чадварыг улам нэмэгдүүлэх талаар анхаарч ажилласан.
- Банкны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, цахим шилжилтийг үргэлжлүүлэх, харилцагчдын үйлчилгээг сайжруулахад чиглэсэн урт хугацааны зорилтуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн.

Жилийн тайланд тусгагдсан энэ хэсэг нь Компанийн засаглал, хянан нийцүүлэлтийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны товч тайлан бөгөөд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу дэлгэрэнгүй тайланг мөн гаргадаг.

Засаглалын бүтэц

ХасБанк нь ТэнГэр Санхүүгийн Нэгдэл (ТЧН) ХХК-ийн бүрэн эзэмшлийн охин компани юм.

Банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Банкны засаглалын дотоод журмын дагуу толгой компани ТЧН ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал Банкны хувьцаа эзэмшигчийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт хувьцаа эзэмшигчдээс сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") нь хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамаарахаас бусад асуудлаар шийдвэр гаргадаг. ТУЗ нь Банкны стратеги, бодлогыг тодорхойлж, эдгээр зорилгод хүрэхэд шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийг бүрдүүлэх төлөвлөгөөг батлах зэргээр Банкныг стратегийн удирдлагаар хангадаг. ТУЗ нь Банкны үйл ажиллагаа хууль тогтоомж, дотоод журам, батлагдсан төлөвлөгөө, төсвийн хүрээнд Банктай нэгдмэл сонирхолтой бүх талуудын эрх ашгийн төлөө явагдаж буй эсэхэд хяналт тавьж, эрсдэлийг илрүүлж, үнэлж, удирдахын тулд дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж ажилладаг.

ТУЗ нь эрх үүргээ хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах үүднээс байнгын хороодыг байгуулж, хороод нь ТУЗ-өөс өгсөн тодорхой чиг үүргийн дагуу ТУЗ-ийн хэлэлцэх асуудлуудаар зөвлөмж дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулдаг, мөн ТУЗ-өөс өгсөн эрх мэдлийн хүрээнд тодорхой асуудлаар шийдвэр гаргадаг. Яаралтай эсвэл онцгой асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор бусад түр хороог байгуулж ажиллуулдаг. Банкны өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-өөс томилогдсон гүйцэтгэх захирал удирдаж явуулдаг. Гүйцэтгэх захирал нь Банкныг төлөөлөн ажиллаж, хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д тогтмол тайлагнах үүрэгтэй.

Хувьцаа эзэмшигчдийн хурал

2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг биечлэн мөн цахим хэлбэрийг хослуулсан байдлаар зохион байгуулж явуулсан. 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Банкны жилийн үр дүн, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцэл, 2022-2026 онд хэрэгжүүлэх стратегийн талаар авч хэлэлцсэн. 2022 онд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал нийт 6 удаа болсон бөгөөд Хувьцааг нийтэд санал болгохтой холбоотой шийдвэрүүдийг гаргахад анхаарч ажилласан.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2021 оны үр дүнгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн нь Банкны хувьд 2 жил дараалан ногдол ашиг тарааж буй түүхэн тэмдэглэлт үйл явдал бөгөөд хувьцааг нийтэд санал болгохоос өмнө хөрөнгө оруулагчдад зохистой ойлголтыг түгээж буй хэрэг юм.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчид, ТУЗ болон гүйцэтгэх удирдлага шийдвэрүүдийн талаар мэдээлэл солилцож, хувьцаа эзэмшигчдийг эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангаж, хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гаргалтыг дэмжиж ажилласан.

ТУЗ-ийн манлайлал

2022 онд ТУЗ-өөс компанийн бизнес төлөвлөгөө, тогтворжуулах төлөвлөгөө, санхүүжилтийн төлөвлөгөө, ногдол ашгийн бодлого, Банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээ, Комплаенсийн хөтөлбөр болон эрсдэлийн удирдлагын бодлого боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих замаар Банкны Гүйцэтгэх удирдлагад дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ банкны тогтвортой байдлыг хамгаалах мөн нээлттэй хувьцаат компани болохтой холбоотой хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн стратегийн удирдамжаар ханган ажилласан.

ТУЗ-ийн бүтэц

ТУЗ нь гишүүн бүрийг асуудлын хэлэлцүүлэгт оролцуулж үр дүнтэй үйл ажиллагааг хангах, нөхцөл байдлыг өргөн цар хүрээтэй харж дүгнэлт гаргаж, түүнийгээ үндэслэн оновчтой шийдвэр гаргахад ТУЗ-ийн бүтэц, гишүүдийн тоо, чадвар, мэргэшсэн дадлага туршлага, Гүйцэтгэх удирдлагын төлөөлөл, хараат бус гишүүдийн оролцоо нь нэн чухал ач холбогдолтой гэсэн зарчмаар ажилладаг.

2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ТУЗ нь нийт 11 гишүүний бүрэлдэхүүнтэй ажилласнаас Гүйцэтгэх удирдлагын төлөөлөл болох 1 гишүүн, Хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн 6 гишүүн, 3 хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн даргын үүргийг хувьцаа эзэмшигч бус, аливаа хувьцаа эзэмшигчийн холбогдох, нэгдмэл сонирхолтой этгээд бус гишүүн гүйцэтгэдэг. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд банкны салбарын олон талын туршлагатай, ур чадвартай гишүүд ажилладаг.



Санжай Гүпта
ТУЗ-ИЙН ДАРГА



Майкл Мадден
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
РОНОК ПАРТНЕРЗ төлөөлөл



Н. Цэлмүүн
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
МОНГОЛЫН АЛТ /МАК/ төлөөлөл



Б. Уламбаяр
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС
ГИШҮҮН



Ив Жако
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
КАНАДЫН ҮНДЭСНИЙ БАНК төлөөлөл



Нираж Вэдва
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС
ГИШҮҮН



Андржеж Витак
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ
ХӨГЖЛИЙН БАНК төлөөлөл



Г. Цэвэгжав
ГЗ, ТУЗ-ИЙН ГИШҮҮН
Компанийн дүрмийн 8.27-д заасны
дагуу ТУЗ-ийн гишүүнээр ажилладаг.



Албертус Браггинк
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
ОРИКС КОРПОРАЦИ төлөөлөл



Сюзанна Хэрринг Карр
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН
КОРПОРАЦИ төлөөлөл



Эрик Версавел
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС
ГИШҮҮН

ТУЗ-ийн хурал

ТУЗ нь Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. ТУЗ-ийн үйл ажиллагааны гол хэлбэр нь ТУЗ-ийн хурал бөгөөд хурлын шийдвэрийг тогтоолоор баталгаажуулж гаргадаг. ТУЗ-ийн ээлжит хурлын чөлөөт цагт ТУЗ-ийн үйл ажиллагааг онлайн болон холбооны бусад хэрэгсэлээр дамжуулан явуулж эчнээ санал хураалтаар шийдвэр гаргадаг зохицуулалттай.

2022 онд Ковид цар тахлын эрсдэл хэдий буурсан ч зарим нэг улс орнуудын хөдөлгөөний хязгаарлалт, мөн хамгаалалтын бусад арга хэмжээнүүдтэй холбоотойгоор үүсэж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах, ТУЗ-ийн үйл ажиллагаа, шийдвэр гаргалтыг тасралтгүй явуулахын тулд ТУЗ нь уян хатан бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хүрээнд үйл ажиллагааны цахим болон биечлэн оролцох хэлбэрийг хослуулан явууллаа.

- Skype, Webex, Zoom зэрэг харилцааны холбооны хэрэгслүүдээр дамжуулан ээлжит болон бусад хурлуудыг зохион байгуулж хуралдуулав.
- Ээлжит хурлын чөлөөт цагт онлайн санал хураалтаар шийдвэр гаргах явдлыг түлхүү ашиглав.
- Шийдвэр тогтоолыг цахим хэлбэрээр онлайн санал хураалтаар шийдвэрлэж гаргав.
- Ээлжит хурлын чөлөөт цагт сар бүр ТУЗ-ийн мэдээллийн чанартай онлайн уулзалтуудыг зохион байгуулав.

2022 онд ТУЗ-ийн 4 ээлжит, 7 удаагийн ээлжит бус хурал, 10 онлайн санал хураалтын хурлуудыг хуралдуулж, ТУЗ-ийн мэдээлэл солилцох 2 удаагийн онлайн хэлэлцүүлэг зохион байгуулж хуралджээ. Хурлуудыг цахим болон биечлэн оролцох хэлбэрийг хослуулан явуулсан байна.

2022 онд ТУЗ нь 64 тогтоол шийдвэр гаргасан ба үүнээс 11 тогтоол шийдвэрийг ТУЗ-ийн хурлыг хуралдуулалгүйгээр онлайн санал хураалтаар гаргасан болно.

Банкны гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн бүх ээлжит хурал, ТУЗ-ийн хороодын болон бусад хуралд оролцож Банкны бизнес, санхүү нягтлан бодох бүртгэл, хянан нийцүүлэлт, засаглал болон банкны үйл ажиллагааны бусад асуудлуудаар шаардлагатай мэдээлэл, тайлбар гаргаж өгдөг.

ТУЗ-ийн хурлын үеэр албан ёсоор харьцаж тайлагнахаас гадна ТУЗ-ийн гишүүд Банкны гүйцэтгэх удирдлагын гишүүдтэй тогтмол албан бус байдлаар харилцах боломжтой байдаг нь удирдлагын баг болон ТУЗ-ийн хооронд нээлттэй хэлэлцүүлэг, мэдлэг туршлага солилцох үйл ажиллагааг хангадаг.

ТУЗ-ийн үнэлгээ

Зохистой засаглалын зарчмын дагуу ТУЗ нь засаглал, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллах зорилгоор хамтын гүйцэтгэлийг үнэлэх, дутагдлыг илрүүлэх, үйл ажиллагааг сайжруулах тодорхой арга хэмжээ авахын тулд жил бүр ТУЗ-ийн үйл ажиллагааны үнэлгээ явуулдаг. Үүнээс гадна тодорхой шалгуурыг үндэслэн ТУЗ-ийн гишүүд өөр хоорондын үнэлгээг тус бүр хийдэг.

ТУЗ-ийн үйл ажиллагааны болон гишүүдийн үнэлгээ нь компанийн засаглалын сайн туршлагад тооцогддог бөгөөд ТУЗ-ийг бэхжүүлэх, сул талыг олж илрүүлэх, чадамжийг дээшлүүлэх, үр дүнг нэмэгдүүлэх, бүтцийн талаар гишүүдийн дунд санал солилцох боломж болохоос гадна үүсгэн байгуулагчид, бусад талуудад өөрийн нэр хүндийг өсгөхөд нөлөөлдөг.

2022 онд ТУЗ-аас үйл ажиллагааны болон гишүүдийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн болно.

ТУЗ-ийн хороод

ХасБанкны ТУЗ нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий 3 байнгын хороотой ба эдгээр хороод нь тодорхой асуудлуудаар мэргэжлийн зөвлөмж гаргаж, ТУЗ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах зорилготой. Хороодын үйл ажиллагаатай холбоотой ерөнхий заалтууд нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулагддаг ба тухайн хороонд хамаарах асуудал нь холбогдох хорооны дүрмээр зохицуулагдана. ТУЗ нь дараах байнгын хороодтой.

- i. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо;
- ii. Эрсдэлийн удирдлагын хороо;
- iii. Аудитын хороо.

ТУЗ-ийн хороод нь тав буюу түүнээс дээш гишүүнтэй байх бөгөөд тэдгээр нь ТУЗ-ийн гишүүн байна.

ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болох бөгөөд Монгол улсын Банкны тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Эрсдэлийн удирдлагын болон аудитын хороодод заавал ажиллах үүрэгтэй.

Олон улсын зохистой засаглалын зарчим, Монголбанкнаас гаргасан журмын дагуу ТУЗ-ийн Аудитын хороог хараат бус гишүүн даргалдаг, ТУЗ-ийн гишүүн гүйцэтгэх захирал ТУЗ-ийн Аудит, Эрсдэлийн удирдлага, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороодын гишүүнээр ажилладаггүй.

Хороодын үйл ажиллагааны гол хэлбэр нь хорооны хурал бөгөөд хорооны шийдвэрийг ТУЗ-д танилцуулах зөвлөмж хэлбэрээр гаргадаг. Хороодын ээлжит хурлууд нь ТУЗ-ийн хурлын өмнөх өдөр товлогддог.

2022 онд байнгын хороодын ээлжит хурлыг 4 удаа улирал бүр биечлэн болон Zoom цахим харилцаа холбооны хэрэгслээр хуралдуулсан. Ээлжит хурлын чөлөөт цагт ТУЗ-ийн хороодын үйл ажиллагааг онлайн болон мэдээллийн бусад хэрэгсэлээр дамжуулан явуулж онлайн санал хураалтаар зөвлөмж гаргаж ажилладаг.

Аудит ба тайлагнал

ТУЗ нь Банкны санхүүгийн тайлан үнэн зөв бэлтгэгдсэн, холбогдох хууль тогтоомж, банкны салбарын зохицуулагч байгууллагын шаардлага болон хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн эсэхэд хяналт тавьж баталдаг. Банкны удирдлага нь ТУЗ-өөр батлуулахаар санал болгосон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-д мэдээлэл тайлбар өгөх, ТУЗ-ийг үндэслэлтэй үнэлгээ дүгнэлт хийж шийдвэр гаргах боломжоор хангах үүрэгтэй.

ТУЗ нь хөндлөнгийн аудиторыг сонгох, томилох, тодорхой хугацааны дараа солих өөрчлөх үүрэгтэй ажилладаг. 2022 онд хөндлөнгийн аудиторроор Эрнст Янг компани аудит хийж ажилласан.

САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ХасБанк ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд

Дүгнэлт

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын хураангуй тайлан болон тухайн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлангаас бүрдсэн Санхүүгийн хураангуй тайланг ХасБанк ХХК ("Банк")-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь санхүүгийн хураангуй тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд "Тайлан бэлтгэх үндэслэл" тодруулгад тайлбарласны дагуу Банкны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байна.

Санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-ын шаардсан бүх тодруулгуудыг агуулаагүй болно. Иймд энэхүү санхүүгийн хураангуй тайлан ба аудиторын дүгнэлт нь Банкны аудитлагдсан санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлтийг орлохгүй.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлт

Бид 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдөр батлагдсан аудитлагдсан санхүүгийн тайлангуудад зөрчилгүй дүгнэлт өгсөн.

Санхүүгийн хураангуй тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн хураангуй тайланг "Тайлан бэлтгэх үндэслэл" тодруулгад тайлбарласны дагуу бэлтгэх нь Банкны удирдлагын хариуцлага юм.

Аудиторын хариуцлага

Бидний үүрэг бол шинэчлэгдсэн Аудитын Олон Улсын Стандарт ("АОУС") 810 буюу "Санхүүгийн хураангуй тайлангийн талаар дүгнэлт өгөх гэрээт ажил"-ын дагуу шаардсан горимуудыг гүйцэтгэж, түүндээ үндэслэн санхүүгийн хураангуй тайланд дүгнэлт өгөх явдал юм.




Ernst & Young Mongolia Audit LLC
Эрнст энд Янг Монголиа Аудит Ххк
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан



Буланбай Хабылхайрат
Захирал

Баталсан



Адриан Чу
Партнер

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2023 оны 3 дугаар сарын 15

Аудитлагдсан санхүүгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилийн

➤ Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлан

	2022 мян.төг	2021 мян.төг
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийн хүү болон түүнтэй адилтгах орлого	362,440,045	322,909,506
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүдийн хүү болон түүнтэй адилтгах орлого	14,218,509	9,176,832
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(156,331,816)	(174,330,045)
Хүүний цэвэр орлого	220,326,738	157,756,293
Хураамж ба шимтгэлийн орлого	30,701,660	26,944,135
Хураамж ба шимтгэлийн зардал	(11,288,762)	(8,019,386)
Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого	19,412,898	18,924,749
Арилжааны цэвэр ашиг	16,983,711	6,194,516
БҮЦАА-д бүртгэсэн бусад санхүүгийн хэрэгслүүдийн цэвэр орлого	3,349,898	3,601,665
Үйл ажиллагааны бусад цэвэр орлого/(зардал)	3,597,709	(374,161)
Үйл ажиллагааны нийт орлого	263,670,954	186,103,062
Үнэ цэнийн бууралтын цэвэр зардал	(9,153,357)	(4,571,200)
Үйл ажиллагааны цэвэр орлого	254,517,597	181,531,862
Үйл ажиллагааны зардал	(109,334,959)	(80,470,954)
Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга	1,506,637	1,407,264
Татварын өмнөх ашиг	146,689,275	102,468,172
Орлогын татварын зардал	(40,850,689)	(27,205,297)
Тайлант жилийн ашиг	105,838,586	75,262,875
Бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):		
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого:</i>		
Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн нөөцийн өөрчлөлт, татварын дараах	854,230	2,653
Барилга, байшингийн дахин үнэлгээний олз	-	2,997,142
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах	854,230	2,999,795
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	106,692,816	78,262,670
Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр):		
Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг	105.84	75.26
Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг	105.84	75.26

2023 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс олгосон эрхийн дагуу энэхүү тайланг нийтлэхийг зөвшөөрөн гарын үсэг зурав.

ГҮМЭНЖАВЫН ҮЗЭЭМЖАВ
(Гүйцэтгэх захирал)



ГАНЗОРИГИЙН ЭРДЭНЭБАЯР
(Санхүү хариуцсан захирал)

(Signature)

Тайлан бэлтгэх үндэслэл. Санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Банкны аудитлагдсан санхүүгийн тайлан дахь Санхүүгийн байдлын тайлан болон Ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.

Аудитлагдсан санхүүгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх
Санхүүгийн байдлын хураангуй тайлан

	2022 мян.төг	2021 мян.төг
ХӨРӨНГӨ		
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	431,341,650	248,313,381
Монголбанк дахь заавал байлгах нөөц	255,682,837	214,231,304
БУЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд		
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	107,798,730	49,223,110
Санхүүгийн хэрэгслүүд	83,897,165	76,288,953
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	102,764,818	90,000,608
БУЦБДО-д бүртгэх санхүүгийн хөрөнгө		
Өмчийн хэрэгслүүд	4,682,289	3,613,197
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө		
Банк ба санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж	282,232,458	42,487,278
Өрийн хэрэгслүүд	596,387,687	926,714,515
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	1,900,052,627	1,701,557,761
Бусад хөрөнгө	71,527,286	60,592,954
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	2,063,167	133,594
Үндсэн хөрөнгө ба ашиглах эрхтэй хөрөнгө	68,221,257	67,214,011
Биет бус хөрөнгө	18,895,588	15,452,521
Хойшлогдсон татварын хөрөнгө	5,232,744	4,135,441
НИЙТ ХӨРӨНГӨ	3,930,780,303	3,499,958,628
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		
БУЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд		
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	1,639,595	371,050
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр		
Банк ба санхүүгийн байгууллагын байршуулсан харилцах, хадгаламж	51,866,980	2,691,406
Харилцагчдын харилцах, хадгаламж	2,438,619,569	2,252,099,731
Зээлээр авсан санхүүжилт	857,363,227	768,775,737
Өрийн үнэт цаас	-	8,403,663
Хойшлогдсон нөхцөлт хандив	7,970,706	9,243,242
Түрээсийн өр төлбөр	5,310,092	5,422,527
Бусад өр төлбөр	68,482,406	64,250,454
Орлогын албан татварын өглөг	23,840,068	4,705,974
НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,455,092,643	3,115,963,784
ЭЗДИЙН ӨМЧ		
Энгийн хувьцаа	100,000,000	100,000,000
Нэмж төлөгдсөн капитал	1,817,773	1,817,773
Нөөцүүд	95,708,103	84,602,413
Хуримтлагдсан ашиг	278,161,784	197,574,658
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ	475,687,660	383,994,844
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	3,930,780,303	3,499,958,628

2023 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс олгосон эрхийн дагуу энэхүү тайланг нийтлэхийг зөвшөөрөн гарын үсэг зурав.



ГАНЗОРИГИЙН ЭРДЭНЭБАЯР
(Санхүү хариуцсан захирал)

Тайлан бэлтгэх үндэслэл. Санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Банкны аудитлагдсан санхүүгийн тайлан дахь Санхүүгийн байдлын тайлан болон Ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.

Аудитлагдсан санхүүгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

➤ Өмчийн өөрчлөлтийн тайлан

	Энгийн хувьцаа мян.төг	Нэмж төлөгдсөн капитал мян.төг	Нөөцүүд мян.төг	Хуримтлагд- сан ашиг мян.төг	Нийт эздийн өмч мян.төг
2022 оны 1 сарын 1- ний өдрийн байдлаар	100,000,000	1,817,773	84,602,413	197,574,658	383,994,844
Тайлант жилийн ашиг	-	-	-	105,838,586	105,838,586
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	854,230	-	854,230
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	854,230	105,838,586	106,692,816
Бэлэн мөнгөөр олгосон ногдол ашиг	-	-	-	(15,000,000)	(15,000,000)
Тусгай зориулалттай нөөцөд шилжүүлсэн	-	-	10,251,460	(10,251,460)	-
2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар	100,000,000	1,817,773	95,708,103	278,161,784	475,687,660
2021 оны 1 сарын 1-ний өдрийн байдлаар	58,625,979	1,817,773	57,851,872	194,936,550	313,232,174
Тайлант жилийн ашиг	-	-	-	75,262,875	75,262,875
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	2,999,795	-	2,999,795
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	2,999,795	75,262,875	78,262,670
Бэлэн мөнгөөр олгосон ногдол ашиг	-	-	-	(7,500,000)	(7,500,000)
Хувьцаагаарх ногдол ашиг	41,374,021	-	-	(41,374,021)	-
Тусгай зориулалттай нөөцөд шилжүүлсэн	-	-	23,750,746	(23,750,746)	-

Нөөцүүдэд тусгай зориулалтын нөөц багтсан ба уг нөөцийг Монголбанкны шаардлагад нийцүүлэн байгуулсан бөгөөд Монголбанкны зөвшөөрлөөр Банкны хувьцаа эзэмшигчид хуваарилах боломжтой.

Аудитлагдсан санхүүгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

➤ Мөнгөн гүйлгээний тайлан

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2022 мян.төг	2021 мян.төг
Татварын өмнөх ашиг	146,689,275	102,468,172
Тохируулга:		
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз /(олз)	4,564	(4,862)
Хураан авсан хөрөнгө борлуулсны гарз	419,419	1,125,540
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө борлуулсны олз	(316,337)	(155,981)
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд борлуулсны гарз	-	156,913
Валютын ханшийн хэрэгжээгүй гарз /(олз)	57,154,258	(21,922,069)
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн БҮЦ-ийн өөрчлөлт	(57,307,075)	26,831,960
Үнэ цэнийн бууралтын цэвэр зардал	6,577,134	2,815,312
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийн гэрээний өөрчлөлтийн алдагдал	3,107,879	3,118,563
Зээлээр авсан санхүүжилтийн гэрээний өөрчлөлтийн ашиг	(531,656)	(1,362,675)
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүдийн БҮЦ-ийн өөрчлөлт	1,344,771	370,512
Өмчийн хэрэгслүүд борлуулсны олз	(106,153)	-
Үндсэн хөрөнгийн элэгдэл	6,285,015	6,339,870
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	3,809,293	3,711,714
Биет бус хөрөнгийн хорогдол	1,952,099	2,910,587
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	89,955	80,098
Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз	114,070	-
Барилга, байшингийн дахин үнэлгээний гарз	-	868,801
Хураан авсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт	(1,126,650)	(3,026,616)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт	-	(116,699)
Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга	(1,506,637)	(1,407,264)
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого	(362,440,045)	(322,909,506)
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн орлого	(20,890,312)	(13,885,992)
Хүүгийн зардал	156,331,816	174,330,045
Хүлээн авсан хүү	305,237,065	264,386,797
Төлсөн хүү	(115,139,635)	(130,131,418)
Үйл ажиллагааны хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	129,752,113	94,591,802
Үйл ажиллагааны хөрөнгийн өөрчлөлтүүд:		
Монголбанк дахь заавал байлгах нөөц	(41,451,533)	(27,858,636)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	(257,749,451)	(421,808,737)
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	63,790,181	21,973,538
Бусад хөрөнгө	(11,710,564)	7,729,405
Үйл ажиллагааны өр төлбөрийн өөрчлөлтүүд:		
Банк ба санхүүгийн байгууллагын байршуулсан харилцах, хадгаламж	49,167,894	750,192
Харилцагчдын харилцах, хадгаламж	91,833,073	229,145,729
Бусад өр төлбөр	(10,801,508)	(2,361,464)
Үндсэн үйл ажиллагаанд хүлээн авсан /(зарцуулсан) мөнгөн гүйлгээ	12,830,205	(97,838,171)
Төлсөн орлогын албан татвар	(23,098,641)	(31,872,211)
Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ	(10,268,436)	(129,710,382)

Аудитлагдсан санхүүгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

➤ Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2022 мян.төг	2021 мян.төг
Өрийн хэрэгслүүдээс хүлээн авсан хүү	60,898,119	73,511,422
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэгслүүдийн худалдан авалт	-	(17,620,921))
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны орлого	541,600	1,152,004
БҮЦБДО-д бүртгэх өмчийн үнэт цаас борлуулсны орлого	176,034	-
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэгслүүд борлуулсны орлого	23,831,383	1,483,100
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	36,774	10,027
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(8,197,714)	(5,380,980)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	(5,509,236)	(3,656,575)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө борлуулсны орлого	878,485	3,085,797
Хураан авсан хөрөнгө борлуулсны орлого	7,576,596	19,410,445
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас хүлээн авсан цэвэр мөнгөн гүйлгээ	80,232,041	71,994,319

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2022 мян.төг	2021 мян.төг
Зээлээр авсан санхүүжилтэд төлсөн хүү	(40,884,194)	(42,300,337)
Өрийн үнэт цаасанд төлсөн хүү	(164,801)	(703,340)
Зээлээр авсан санхүүжилтийн татан авалт	368,524,931	172,827,206
Зээлээр авсан санхүүжилтийн эргэн төлөлт	(344,835,822)	(334,803,370)
Өрийн үнэт цаасын эргэн төлөлт	(8,262,767)	(2,000,000)
Төлсөн ногдол ашиг	(15,000,000)	(7,500,000)
Хүлээн авсан хойшлогдсон нөхцөлт хандив	234,101	331,540
Түрээсийн үндсэн өр төлбөрийн төлөлт	(3,965,980)	(3,703,188)
Санхүүгийн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ	(44,354,532)	(217,851,489)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлтийн нөлөө	80,503,259	(1,285,402)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)	106,112,332	(276,852,954)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,172,353,926	1,449,206,880
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,278,466,258	1,172,353,926

Аудитлагдсан санхүүгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

➤ Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

	2022 мян.төг	2021 мян.төг
Санхүүжилтийн үйл ажиллагаанаас үүдэлтэй өр төлбөрүүдийн өөрчлөлт:		
Түрээсийн өр төлбөр		
1-р сарын 1-нээр	5,422,527	3,176,591
Нэмэгдсэн мөнгөн бус гүйлгээ	3,706,778	5,393,450
Цуцлагдсан түрээс	(171,252)	-
Хүүгийн зардал	318,019	555,674
Төлсөн түрээсийн төлбөр	(3,965,980)	(3,703,188)
12-р сарын 31-нээр	5,310,092	5,422,527
Зээлээр авсан санхүүжилт		
1-р сарын 1-нээр	768,775,737	937,585,863
Шинээр нэмэгдсэн	368,524,931	172,827,206
Эргэн төлөлт	(344,835,822)	(334,803,370)
Хүүгийн эргэн төлөлт	(40,884,194)	(42,300,337)
Монголбанк болон Засгийн газарт МИК - Давуу эрхтэй ИЗББондоор төлсөн мөнгөн бус хөдөлгөөн	(48,088,000)	(9,500,800)
Ханшийн зөрүү	112,494,895	(163,970)
Хуримтлагдсан хүүгийн зардал	41,907,336	46,493,820
Гэрээний нөхцөл өөрчлөлтийн ашиг	(531,656)	(1,362,675)
12-р сарын 31-нээр	857,363,227	768,775,737
Өрийн үнэт цаас		
1-р сарын 1-нээр	8,403,663	10,618,643
Эргэн төлөлт	(8,262,767)	(2,000,000)
Хүүгийн эргэн төлөлт	(164,801)	(703,340)
Ханшийн зөрүү	1,268	(2,061)
Хуримтлагдсан хүүгийн зардал	22,637	490,421
12-р сарын 31-нээр	-	8,403,663